


“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ТӨХХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН


(2025.01.01-2025.12.31)

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
яамны байрны 1 давхар, Дархан Юнайтед
Арена спорт цогцолбор, 14 дүгээр баг,
Дархан сум, Дархан-Уул аймаг, Монгол Улс



Агуулга

НЭГ. ЗАХИРГАА, САНХҮҮ	2
ХОЁР. АРИЛЖАА	24
ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА.....	29
ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛ, БҮРТГЭЛ.....	30
ТАВ. ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ	33
ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА.....	35
ДОЛОО. ДҮГНЭЛТ.....	43



НЭГ. ЗАХИРГАА, САНХҮҮ

1.1. Хууль, эрх зүй:

- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг 2025 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор биржээр арилжсан самнасан ноолуурын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 0.62 хувь байхаар тогтоов.
- Гүйцэтгэх захирлын 2025 оны А/10 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталлаа.
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Шүүхэд дуудан ирүүлэх тухай Мэдэгдэх хуудсыг хүлээн авч, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Нэхэмжлэгч Д.Билгүүний ажилд эргүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шитгэлийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хүлээн авсан ба Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэлийн хариу тайлбарыг өгөхөөр Хөдөө аж ахуйн биржээс 2 удаагийн шүүх хуралд оролцлоо. Шүүхийн эцсийн шийдвэр гараагүй бөгөөд тодорхой шалтгаануудын улмаас шүүх хурал хойшлогдоод байна.
- Биржийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, давхардлыг арилгах болон хэрэгжилт хангалтгүй зүйл, заалтыг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар нийт ажилтнуудын хурлаар хэлэлцэж, тодорхойлсноор хүчинтэй нийт 46 дүрэм, журам байгаагаас Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/64 дугаар тушаалаар чиг үүргийн хувьд давхардсан, хэрэгжилт хангалтгүй байгааг хүчингүй болгож, одоогийн байдлаар нийт 23 дүрэм, журам мөрдөгдөж байна.
- Биржийн гэрээний стандартаас зарим бараа, түүхий эдийн “Спот гэрээний стандарт”-ыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны А/72 дугаар тушаалаар шинэчлэн баталсан болно.

1.2. Санхүү, аж ахуй:

- Компанийн Дархан-Уул аймагт шилжин ирсэн хөдөлгөөнтэй холбогдуулан байгууллагын хаягийн өөрчлөлтийг хийлгэн Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга тэмдэгийг солиулав.
- Нийгмийн даатгалын хаягийн өөрчлөлт хийж Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын газарт шилжин ирж бүртгүүлэв.
- Компанийн 2024 оны Санхүүгийн тайланг иж бүрэн хэлбэрээр гаргаж, Үндэсний аудитын газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого

зохицуулалтын газар, Санхүүгийн зохицуулах хороо, “Цэгц төв богд аудит” ХХК-иудад хуульд заасан хугацаанд албан бичгээр хүргүүллээ.

➤ Компанийн 2024 оны Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлан болон бусад татварын тайлангуудыг иж бүрэн хэлбэрээр гаргаж, Татварын хууль тогтоомжид заасан хугацаанд цахим системээр тайлагналаа.

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар “Биржээр арилжих самнасан ноолуурын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 17 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 03 дугаар тогтоол, “Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус баталлаа.

➤ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн ногдол ашиг хуваарилахыг дэмжих тухай 08 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэрийн дэргэдэх агуулахад байршсан ноолуурыг барьцаалан энгийн вексель гаргах замаар ноолуурын бэлтгэлийг хангуулах, үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 10 дугаар тогтоолыг тус тус баталсан.

➤ Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй бүхий л салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудаас авч буй 2024 оны ДНБ-ийг тооцоход шаардлагатай албан ёсны статистик мэдээг батлагдсан маягтын үзүүлэлт тус бүрээр хуулиар хүлээсэн үүргийн дагуу гаргаж www.aanb3.nso.mn цахим системээр хүргүүллээ.

➤ Компанийн албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа бараа материал, үндсэн хөрөнгөд хуулийн дагуу жилд 2 удаа тооллого явуулж, илүүдэлтэй ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж компанийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт танилцуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаж байна.

➤ “Эрчист монгол” ТӨХХК-ийн 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/40 тоот албан бичгийн дагуу Компанийн ерөнхий мэдээлэл, Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний гүйцэтгэлийг 2020-2025 онуудын гүйцэтгэлээр, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын тайланг 2020-2024 онуудын байдлаар, Санхүүгийн иж бүрэн тайланг, тодруулгын хамт эксель файлаар 2020-2025 онуудын байдлаар, Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн судалгааг 2020-2025 онуудын байдлаар гарган цахимаар хүргүүллээ.

➤ 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн урьдчилсан гүйцэтгэлийг бэлтгэж, санхүүгийн байдал, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, хөдөлгөөнд тухай бүр дүгнэлт хийж, Гүйцэтгэх захиралд танилцуулан ажиллаж байна.

➤ Компанийн 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан гарган, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

1.3. Дотоод хяналт, мониторинг:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн ил тод болгох мэдээллийг хуулийн хугацаанд нь www.shilendans.gov.mn, www.mce.mn цахим талбарт тогтмол оруулан ажиллаж байна.
- Төрийн мэдээллийн сангийн www.mofa.igovernment.mn цахим системд хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн хэрэгжилт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад эрх бүхий албан тушаалтнаас тусгайлан өгсөн тушаал, үүрэг даалгаварын биелэлтийг цаг тухай бүр гарган тайлагнаж байна.
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд томилогдохоор нэр дэвшүүлсэн 9 албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайланг албан тушаалтан тус бүрээр гаргуулан, хуулийн хугацаанд <https://meduuleg.iaac.mn/AOS/Logout> цахим системд тайлагнаж, 4 албан тушаалтны 2024 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн тайланг цахим системээр хүлээн авч, хуулийн хугацаанд нь баталгаажууллаа.
- Монгол Улсын Их хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Их хурлын 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны 2025 оны “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоолын дагуу Гүйцэтгэх захирлын 2025 оны А/08 дугаар тушаалаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, мөрдөн ажиллаж байна.
- Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагаанд тандалт хийх тухай 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн удирдамжийн дагуу ажлын хэсэгт биржийн үйл ажиллагаанд хамаарах баримт бичгүүдийг цаг тухай бүр үнэн зөв гарган өгч, хамтран ажиллаж байна.

1.4. Хүний нөөц, сургалт:

- Олон улсын жишигт бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааг амжилттай авч явах, хөгжүүлэх чухал хүчин зүйлийн нэг бол чадварлаг баг, боловсон хүчин байдаг. Биржийн үйл ажиллагаа нь түүний гишүүд болон харилцагчдад найдвартай үйлчилгээ үзүүлэх чадварлаг хүний нөөц дээр тулгуурлах бөгөөд мэдлэг, туршлагатай хүний нөөцийг эрэлхийлж, тасралтгүй хангагдаж байх нь чухал юм. Биржийн зүгээс энэ салбарт ажиллаж туршлага хуримтлуулсан чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, шинээр чадвар, туршлагатай ажилтан авч ажиллуулахаар зорин хүний нөөцийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байна.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар эрхэлсэн ажил, салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж онцгой амжилт гарган, эх орныхоо хөгжил дэвшилд

үнэтэй хувь нэмэр оруулсан Хөдөө аж ахуйн биржийн ажилтан, албан хаагчид төрийн дээд одон, медалиар шагнагдлаа.

➤ “Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын жендерийн тэгш байдлыг сайжруулах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаа, үр дүнтэй танилцах уулзалт, сургалт”-д Жендэрийн үндэсний хорооны ажлын алба, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны жендэрийн салбар зөвлөлийн гишүүд, яам болон түүний харъяа байгууллагуудын хамтаар хамрагдсан.

➤ Дархан-Уул аймагт НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулсан “Онцгой байдлын үед мал, амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандарт” сургалтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харъяа байгууллагуудын хамтаар хамрагдсан.

➤ Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар зохион байгуулж буй “Төвийн бүсийн Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан аймаг, сумын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт”-д харъяа байгууллагуудын хамт оролцлоо. Тус сургалтаар салбарын бодлого, хууль тогтоомж, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”, “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн хөнгөлөлттэй зээлийн журам, 2025 оны ЖДҮХС-ийн санхүүжилтийн талаар мэдээлэл өгсөн. Энэхүү арга хэмжээнд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, санал солилцлоо.

➤ “Төвийн бүсийн хоршоологчдын зөвлөгөөн”-д Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар танилцуулга мэдээлэл өгч, оролцогч хоршоодын төлөөллөөс ирүүлсэн асуултад хариулт өглөө.

➤ Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Тогтвортой байдлын олон улсын стандартын зөвлөл”-өөс баталсан “СТОУС Тогтвортой байдлын олон улсын тодруулгын стандарт”-ын сургалтад хамрагдлаа.

➤ Дархан-Уул аймаг дахь Ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хурлын танхимд тариалан эрхлэгчдэд зориулсан “Тосны ургамал, эрдэнэшиш, шар буурцаг зэрэг сэлгээний таримлыг тариалах технологи, ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд стандартын шаардлага хангасан үрийн нөлөө, таримлын үйлдвэрлэлийн цогц шийдлийг тодорхойлох тухай сургалт”-ыг боллоо. Тус сургалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК, Монголын тариаланчдын холбоо нь “Ачит агро” ХХК-тай хамтран зохион байгуулсан бөгөөд оролцогч тариалан эрхлэгчдэд Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зураглал, биржийн арилжаанд оролцох алхам, тосны ургамлын арилжааны талаар танилцуулга, мэдээлэл олголоо.

➤ Дархан-Уул, Төв, Хэнтий, Хөвсгөл, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудад зохион байгуулагдсан “Атрын IV аян” хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнд Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зураглал, биржийн арилжаанд оролцох алхам, үрийн болон хүнсний улаанбуудайн арилжаа, сэлгэн таримлын үрийн арилжааны зураглалын талаар танилцуулга, мэдээлэл олгож, санал солилцлоо.

- “Амжилтын алхам” сургалтын төвөөс зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт”-ийн 14 хоногийг сургалтад хамрагдсан.
- "Security Transformation Forum 2025" арга хэмжээ "Cyber Security in Age of AI" сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан ба тус арга хэмжээнд оролцлоо.
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагт зохион байгуулагддаг улс орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага, сургалтад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харъяа байгууллагуудын хамтаар оролцож бэлэн байдлыг хангаж ажилласан.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2025 оны А-1/278 тоот албан бичгийн дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-ийг нэвтрүүлэх ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харъяа байгууллагуудыг хамруулсан цахим сургалтад хамрагдлаа. Дээрх уулзалтаар “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-ийг нэвтрүүлэхтэй холбоотой мэдээллүүдийг дэлгэрэнгүй байдлаар авч, цаашид хэрхэн байгууллагын хэмжээнд дээрх ажлыг зохион байгуулж ажиллах талаар үүрэг чиглэл авсан.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас төрийн өмчийн тооллогын системд Эд хөрөнгийн тооллогын тайлан, мэдээ авахтай холбогдуулан шилжилтийн цахим систем ашиглаж 2024 оны санхүүгийн тайлан хөрөнгийн хөдөлгөөн хийх тухай сургалтад хамрагдсан.
- “Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, тайлагналд анхаарах асуудал”-аар байгууллагуудын дарга, нягтлан бодогч, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга, гишүүдэд чиглэсэн цахим сургалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан ба түүнд Хөдөө аж ахуйн биржийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээр хамрагдлаа.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн өмчит компанийн засаглал, олон улсын туршлага, цаашдын чиг хандлага” сургалтад хамрагдлаа. Тус сургалтыг Азийн хөгжлийн банкны гадаад зөвлөх, төрийн өмчийн компаниудын шинэчлэл, засаглалын эксперт Christopher E.Russell удирдаж, төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгон шалгаруулалт, ажлын үр дүн болон компанийн засаглалын цаашдын чиг хандлага зэрэг сэдвүүдээр илтгэл тавив.
- “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-аас зохион байгуулсан “Экспортод гарч буй ноос, ноолууран ширхэгт материалын ангилал, нэршил, чанар, стандартын мэдлэг олгох сургалт”-д Гаалийн ерөнхий газрын улсын байцаагч, хяналтын байцаагч, Гаалийн Төв лабораторийн шинжээчдийн хамтаар хамрагдлаа. Цаашид төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хяналтын байцаагч, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, гаалийн холбогдох ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмолжуулах, ноолуурын салбарт самнасан ноолуурын техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, чанар, хяналтын баталгаажуулалтыг хийх талаар оролцогч талууд харилцан ярилцлаа.

➤ Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 93 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2025 оны н/01 дугаар тушаалын дагуу Улсын онцгой комиссын шуурхай штабаас өгсөн үүргийн дагуу Гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах, эрсдэлийг бууруулах зорилгоор команд штабын сургалтад хамрагдлаа.

➤ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын шуурхай үүрэг даалгаварын хүрээнд өгсөн чиглэлийн дагуу компанийн ажлын гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах, үнэлэх “Able erp систем”-ийг Хөдөө аж ахуйн бирж ашиглахтай холбогдуулан систем ашиглалтын сургалтад хамрагдсан ба ажлын байрны цахим соёл хүний нөөц, албан бичгийн Able системийг амжилттай нэвтрүүлж, Гүйцэтгэх захирлын А, Б тушаал, ирсэн албан бичиг болон мэргэжилтнүүдэд өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын төлөвлөлтийг тус системд бүртгэх, холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэж, системийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

➤ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/216 дугаар тушаалаар МУИХ, МУЗГ-аас баталсан урт болон дунд хугацааны хөтөлбөр, Атрын IV аян, МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах, хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг хангуулах, тариалсан таримлын төрөл зүйлийг тодорхой болгох, ургамал хамгааллын бодис бордооны хэрэглээ, хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээг зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийх, урьдчилсан байдлаар таримлын үе шатыг тодорхойлох ажлаар 2025 оны 07 дугаар сарын 01-09-ний өдрийг дуустал хугацаанд Зүүн, Баруун, Төв, Хангайн бүсэд ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.

➤ Монгол Улсад хэрэгжиж буй гадаадын төсөл хөтөлбөрүүдийн "Хөдөө аж ахуйн салбарт төлөвлөж буй Дасан зохицох арга хэмжээний тойм" сургалт, хэлэлцүүлэгт оролцлоо.

➤ “Mind Tech” Сэлэнгэ үйлдвэрийн зохион байгуулж буй “Тосны ургамал тариаланчдын зөвлөгөөн 2025” Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Шандас өгөөж” ХХК-ийн талбайд амжилттай зохион байгуулагдлаа. Тус зөвлөгөөнд оролцсон тослог ургамал тариаланчид, газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн үйл ажиллагааг танилцуулсан бөгөөд энэ жилээс эхлэн тосны ургамал биржээр арилжих болсонтой холбогдуулан дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хэрхэн арилжаанд оролцох, түүний давуу тал зэрэг мэдээлэл өгч ажиллалаа.

➤ “Хамтдаа бүтээх ирээдүй” сэдвийн хүрээнд, хөрөнгө оруулалт, хүний нөөцийн хөгжүүлэлт, ICT инновац, хөдөө аж ахуй болон Монгол-Япон хоёр орны хоорондын шинэ бизнесийн боломж, бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал болон цаашдын хөгжлийн талаар илтгэл, панел хэлэлцүүлэг болон нэтворкинг үйл ажиллагааг МҮХАҮТ дээр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-тай хамтран ажиллаж буй Япон улсын “Озава тент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Озава Масаши тус арга хэмжээнд илтгэгчээр оролцож “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн талаар форумд оролцогч төлөөлөгчдөд танилцуулга хийв.

➤ “Монгол-Хятадын V экспо” БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ы Хөх хотноо 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр нээлтээ хийлээ. Энэ

удаагийн экспод Монгол Улсаас 350 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, гоо сайхан, бэлэг дурсгал, арьсан эдлэл, хүнс зэрэг 700 гаруй нэр төрлийн органик бараа бүтээгдэхүүнтэй оролцлоо. “Монгол Улс, БНХАУ-ын төр, үйлдвэрлэл, боловсрол, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр Монгол-Хятадын төр, хувийн хэвшил, үйлдвэр, боловсрол, судалгаа шинжилгээ салбарын төлөөллүүд ногоон, дижитал эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны зөөлөн болон хатуу дэд бүтцийг сайжруулах зэрэг өргөн хүрээнд хамтран ажиллах талаар харилцан санал солилцлоо. Тус арга хэмжээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-иас мөн оролцлоо.

➤ Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар болон Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм нар Дархан-Уул аймагт ажиллан “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцлоо

➤ АНУ-ын Үр тарианы зөвлөлийн Хятад дахь захирал Мануэл Санчез, Бээжинд суугаа АНУ-ын Хөдөө, аж ахуйн яамны Гадаад хамтын ажиллагааны албаны атташе Эрик Муллис, Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамны төлөөллийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр хоёр талын хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, тэр дундаа АНУ-ын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид Монгол Улстай хамтран ажиллах чиглэлүүдийг онцлон ярилцав.

➤ Төрөөс хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” цогц төлөвлөгөө, “Атрын IV аян” зэрэг бодлого хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг улсын /ахлах/ байцаагч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг ХХААХҮЯ-аас зохион байгууллаа. Тус сургалтаар биржийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, 2025 оны намрын ургацаас хураасан тосны ургамлын дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлох арилжааг биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны зураглал, хэрхэн биржээр дамжуулан арилжих талаар танилцуулга хийлээ.

➤ Австрали улсад “Монгол, Австралийн тогтвортой санхүү, бизнесийн солилцоо” воркшоп уулзалт зохион байгуулагдлаа. Монголын байгалийн өв сангийн ажлын алба, Удирдах зөвлөл, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Хөгжлийн Холбоо (ТоС Холбоо), Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК болон арилжааны банкуудын удирдлагуудын төлөөлөөс бүрдсэн баг бүрэлдэхүүн Австрали улсын Сидней хотод “Монгол, Австралийн тогтвортой санхүү, бизнесийн солилцоо” воркшоп уулзалтыг ТоС Холбоотой хамтран амжилттай зохион байгуулж оролцлоо. Мөн Австралийн мах, хөдөө аж ахуйн ханган нийлүүлэлтийн сүлжээний томоохон оролцогч Meat and Livestock Australia байгууллага, Нидерланд улсад төвтэй Австралийн хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Rabobank Australia байранд зочилж, байгаль орчинд ээлтэй тогтвортой хөдөө аж ахуйн санхүүжилтийн бодлого, зээлийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх туршлагатай танилцлаа.

- Монгол Улс болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу мах, махан болон ноос, ноосон бүтээгдэхүүн нийлүүлэх уулзалт зохион байгууллаа. Энэ үеэр Бүгд Найрамдах Узбекистан Улсын Хөрөнгө оруулалт, аж үйлдвэржилт, худалдааны яам, Мал эмнэлгийн газар, Арьс шир, ноос, гутлын үйлдвэрлэлийн холбоо, Нэхмэлийн үйлдвэрлэлийн холбоотой тус тус уулзалт хийж Монгол Улсаас сэврээсэн мах болон махан бүтээгдэхүүн, самнасан ноос болон ноосон бүтээгдэхүүн нийлүүлэх, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний дэлгүүрийг хоёр талд байгуулах, мэргэжилтэн бэлтгэх талаар санал солилцож, харилцан тохиролцов. Уулзалтад Монгол Улсын талаас ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суугаа Элчин сайд, “Биокомбинат” ХХК, “Зээлийн батлан даалтын сан, “Хөдөө аж ахуйн бирж” ХКК, “Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо”, “Хүнс комплекс”, “Сүхбаатар мах маркет”, “Завхан хүнс групп” ХХК-ийн төлөөлөл оролцлоо.
- Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу мах, махан болон ноос, ноосон бүтээгдэхүүн нийлүүлэх уулзалт зохион байгууллаа. Бүгд Найрамдах Киргиз Улсын Усны нөөц, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн яам, Үндэстний Хөрөнгө оруулалтын сан, Киргиз-Азербайжаны хөрөнгө оруулалтын сан, Киргизийн ноосны үндэсний холбоотой тус тус уулзалт хийж Монгол Улсаас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга нийлүүлэх, зээлийн батлан даалтын сангийн туршлага солилцох, Касиет ээрмэлийн үйлдвэрийг сэргээх талаар санал солилцож, харилцан тохиролцож тэмдэглэл үйлдэв.
- Монголын экспортын кластерын сүлжээ (МЭКС)-ээс зохион байгуулсан “Экспортын Кластерууд: Санхүүжилтэд Хүрэх Боломж” дугуй ширээний хэлэлцүүлэгт оролцлоо. Энэхүү арга хэмжээнд экспортод чиглэсэн ЖДҮ кластерын байгууллагууд, банк санхүүгийн байгууллагууд, хөгжлийн түншүүдийг нэг дор цуглуулж, экспортын санхүүжилтийн шийдлүүд , шинэ боломжуудыг хэлэлцэж, талуудын цаашдын үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой юм.
- “Амьдралын эрүүл дадал зуршил, харилцаа хандлага” сургалтад хамрагдлаа.
- Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан "Төрийн болон албаны нууцын хууль тогтоомж, цаашид анхаарах асуудал" сэдэвт сургалтад хамрагдлаа.
- "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн албан хаагчид Төрийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ олгох сургалтад хамрагдлаа.
- “Ай Ти Зоон” ХХК-ийн жил бүр тогтмол зохион байгуулдаг Techweek арга хэмжээнд хамрагдлаа. Форумар орчин үеийн цахим орчинд өгөгдлийн сан дээр хиймэл оюу ухаан хэрхэн ажиллах, бусад халдлагаас сэргийлэх талаар мэдээлэл авсан.
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулсан “Худалдааны бичиг баримт, түүний ач холбогдол” сэдэвт сургалтад хамрагдлаа.
- Бүгд найрамдах хятад ард улсын Жианшин хотод зохион байгуулагдсан олон улсын стандартчиллын байгууллагын (ISO) Хөдөө аж ахуйн техникийн хорооны (ISO/TC 38/N4790) ажлын хэсгийн 10 дугаар хуралд биржийн төлөөлөл оролцлоо.

1.5. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

- Компанийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад хамтын ажиллагааг хамтран хэрэгжүүлэх боломжтой ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг бирж, олон улсын байгууллага болон төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлох, хамтын ажиллагааг эхлүүлэн тогтвортой үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Биржийн гадаад хамтын ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулсан ба тэдгээртэй харилцаа холбоо тогтоох ажлыг эхлүүлээд байна.
- 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн “Шинэлэг шийдэл” хөтөлбөрийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх, тогтвортой байдлыг хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээнд харъяа байгууллагуудын хамт оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь мал аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлтийг дэмжих, шинэлэг шийдлийг түгээн дэлгэрүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд тус төслийн зохицуулагч болон шинжээчидтэй тусгайлан уулзаж хоёр байгууллагын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.
- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, төрийн байгууллагууд, арилжааны банкууд болон ноос ноолуур, арьс ширний салбарын аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлж эхэлсэн. Малын гаралтай түүхий эдийн боловсруулах, үйлдвэрлэлийг дэмжих зорилготой уг хөдөлгөөний төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг 2025 оны 2 дугаар сарын 20-ний өдөр Төрийн ордонд болсон ба тус арга хэмжээнд оролцлоо.
- УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнээр ахлуулсан, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан нарын бүрэлдэхүүнтэй “Хүнс, эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсонгуй болгох асуудлын судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд Дархан-Уул аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ажиллах үеэр Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцлоо.
- УИХ-ын гишүүн С.Лүндэг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль болон хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тогтолцоог төгөлдөржүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, уялдаа холбоог сайжруулах талаар санал солилцлоо.
- “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүн УИХ-ын гишүүн Д.Батлут, Ж.Батжаргал нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагаатай танилцах үеэр Хөдөө аж ахуйн биржээр зочлон биржийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцлоо.
- Монгол Улсын Их Хурлын Гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат, Б.Баярбаатар нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн яаманд ажиллах үеэр Хөдөө аж ахуйн биржээр зочлон биржийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцлоо.

➤ НҮБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгч болон АНУ-ын ЭСЯ-ны албаны хүмүүсийг Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнтэй уулзалтад хийсэн ба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагаатай танилцах үеэр Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар товч танилцуулга өгч, санал солилцлоо.

➤ Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлага, албан хаагчид Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай танилцлаа. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд үүсгэн байгуулагдсан хоршоодын түүхий эдийг биржээр дамжуулан экспортод гаргах, мөн “Атрын 4” аянтай холбоотой Увс аймгийн тариаланчдыг үрийн дуудлага худалдаанд идэвхтэй оролцуулах талаар санал солилцлоо.

➤ “Атрын IV аян” хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөн 2025 оны 3 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан ба тус зөвлөгөөнд оролцож

➤ Тариалан эрхлэгчдэд Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зураглал, биржийн арилжаанд оролцох алхам, үрийн болон хүнсний улаанбуудайн арилжааны талаар танилцуулга, мэдээлэл олгож, санал солилцлоо.

➤ Иргэний зориг ногоон намын УИХ-ын гишүүд болон ажлын хэсгийнхэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагаатай танилцах үеэр Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцлоо.

➤ Хөдөө аж ахуйн биржийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын Олон улсын худалдааг дэмжих хорооны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын тэргүүн төлөөлөгч Н.Баатар, Менежер Г. Баярмагнай нар Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцлоо.

➤ “Биржүүдийн хөгжлийн төлөв” дугуй ширээний уулзалтад Гүйцэтгэх захирал Х.Отгонбаяр оролцож Хөдөө аж ахуйн биржийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөө, шийдэл, хамтын ажиллагааны боломжийн талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

➤ Монгол Улсын Их Хурлын 2024 онд 63 дугаар тогтоолоор баталсан “Цагаан алт” хөдөлгөөн”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо хөдөлгөөн” болон хөдөө аж ахуйн салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхэд малын гаралтай түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, салбарын эдийн засгийг тогтвортой өсгөх, тэр дундаа арьс шир, ноос, ноосон бүтээгдэхүүн, ноолуурын зах зээлийг тэлэх, экспортыг шинэ шатанд гаргахад хамтын ажиллагааны үр дүнтэй үйл ажиллагааг бүрдүүлж, холбогдох дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллах зорилгоор “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо”, “Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо” болон “Монголын ноос, ноолуурын холбоо”-той “Хамтран ажиллах санамж бичиг” байгууллаа.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор баталсан “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг 2025 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Хөдөө аж ахуйн биржээр арилжих ямааны самнасан ноолуурын болон бусад малын гаралтай түүхий эдийн чанарын баталгаажуулалтыг хангуулах, техникийн зохицуулалтыг мөрдөн ажиллаж, хяналтыг сайжруулах талаар “Монголын хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо” ТББ-тай цахим уулзалт хийж, санал солилцлоо.

➤ Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг шинэ шатанд хүргэх зорилгоор Япон Улсын “Озава Тент” ХХК-тай хамтран ажиллах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтын хүрээнд мембран материалыг ашиглан агаарын давхарга үүсгэх технологид суурилсан өндөр чанарын агуулахыг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлэх, туршилтын төслийг хамтран хэрэгжүүлэхээр хэлэлцэж, санал солилцлоо.

➤ “Монгол-Өвөр Монголын Бизнесийн холбоо”-той гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт хийлээ. Тус уулзалтаар Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагддаг 8 нэр төрлийн бараа, түүхий эдийн арилжааны зураглал, Өвөр Монгол дахь худалдан авагчдыг биржийн арилжаанд татан оролцуулах боломжийн талаар танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

➤ “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны Ерөнхийлөгч Ц.Алтантуяатай уулзаж хоршоодыг хөгжүүлэх, чадавхжуулах, хоршоодын бэлтгэсэн түүхий эдийг олон улсын зах зээлд нийлүүлэх гарцыг тодорхойлох болон цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар харилцан санал солилцлоо.

➤ “Мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн дундын хоршоог чадавхжуулах, түүхий эдийн тогтмол нийлүүлэлт хийх чадамж бүхий хоршоодыг төлөвшүүлэхэд хамтран ажиллах чиглэлээр “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо”-ны Ажлын албаны дарга Ё.Азжаргал, Бодлого зохицуулалт хариуцсан ахлах шинжээч Х.Сүхбаатар нартай уулзалт хийсэн. Уулзалтаар:

- Шинэ хоршоодыг сургах, чадавхижуулах;
- Шинэ хоршоог дундын хоршоо болгох, кластержуулахад талуудын оролцоог нэмэгдүүлэх, тогтмол нийлүүлэлт хийх чадавхи бүхий хоршоодыг төлөвшүүлэхэд талуудын ажлыг уялдуулах;
- Хамтарсан туршлага судлах, зах зээлийн холболтуудыг хийх боломжийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлаар хэлэлцэж, санал солилцлоо.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд гурван бүсэд загвар дундын хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг байгуулахаар тохиролцож, улмаар дундын хоршооноос нийлүүлэгдэх хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэхээр шийдвэрлэсэн боловч 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн МУЗГ-ын ээлжит хуралдаанаар Үндэсний хороо, Зөвлөлүүдийг татан буулгасан тул тус ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.

➤ “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Гүйцэтгэх захирал Б.Саруул, Худалдааны бодлогын газрын захирал Д.Адъяасүрэн нартай хоёр байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар экспортын баримт бичгийн бүрдүүлбэр, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Хөдөө аж ахуйн биржийн хууль эрхзүйн орчинг сайжруулж, бэхжүүлэх зэрэг асуудлуудаар хэлэлцэж, санал солилцсон ба “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь тус танхимын гишүүнээр элсэхээр тогтож, шаардлагатай баримт материалын бүрдүүлэлтийг хийн Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүн боллоо.

➤ “Монгол-Туркменистаны бизнес форум” Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын их танхимд зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон. Тус арга хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, Мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцсон бөгөөд форумд Туркменистан улсын бараа, түүхий эдийн биржийн дарга Батыр Волсахатов илтгэн тавьж, тус биржийн үйл ажиллагаа, тээвэр, ложистикийн талаар мэдээлэл солилцлоо.

➤ Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа болон Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүхтэй хоёр байгууллагын хамтын ажиллагаа болон Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний баталгаажуулалтын хэрэгжилтийн талаар уулзалт хийлээ. Тус уулзалтаар Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар харилцан санал солилцлоо. Хоёр байгууллагын хооронд экспортын үйл ажиллагаатай холбогдуулан харилцан мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

➤ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн экспортын, гарал үүслийн, арилжааны мэдээний зөрүүг арилгах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгохтой холбоотой асуудлаар Гаалийн ерөнхий газартай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах тухай “Хамтын ажиллагааны гэрээ”-ний төслийг бэлтгэж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын гарын үсэг бүхий албан тоотуудыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Хамтын ажиллагааны асуудлаар Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газар, Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Хуулийн хэлтсийн дарга, ахлах байцаагч нартай албан уулзалт хийлээ. Уулзалтаар “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын хилээр гарч, орж буй хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд хяналт тавих арга хэмжээнд Гаалийн ерөнхий газартай гэрээ байгуулан хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж, санал солилцсон.

➤ Монголын байгалийн өв сангийн The Nature Conservancy олон улсын байгууллага буюу TNC байгаль хамгааллын байгууллагатай уулзалт хийлээ. Уулзалтаар тусгай хамгаалалттай бүсэд нутаглах малчдын мал болон малын гаралтай түүхий эдийг биржийн системээр дамжуулан эдийн засгийн эргэлтэнд оруулах, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах талаар санал солилцож, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх эхлэлийг тавьлаа.

➤ “Ачит агро” ХХК-ийн импортоор оруулж ирсэн тосны ургамлын үрийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдан авч тариалсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн тариалалтын нөхцөл байдалтай танилцахаар Чинза-5, Чинза-7 сортын тосны ургамлын үр нийлүүлэгч БНХАУ-ын аж ахуйн нэгжийн төлөөлөл тосны ургамал тариалалтын мэргэшсэн агрономич нарын хамтаар Монгол Улсад хүрэлцэн ирж тариалангийн талбай тус бүрийн тариалалтын нөхцөл байдалтай танилцаж, ургацын онцлогт тохирох арчилгаа тордолгоо, авч хэрэгжүүлэх арга технологийн зөвлөмжүүдийг тариалан эрхлэгчдэд өгч, мэдээлэл солилцон ажиллалаа. Энэ үеэр Хөдөө аж ахуйн биржээс тариалан эрхлэгчдэд 2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамал дотоодын болон импортын үрийг биржийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлохдоо биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, тосны ургамлын биржийн арилжааны талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

➤ “Агро Мофа” ХХК-ийн төлөөлөл болон Япон Улсаас ирсэн агрономич нарт Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг танилцуулж, биржийн арилжааны талаар мэдээлэл өгч санал солилцсон. Уулзалтыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газартай хамтран зохион байгуулсан ба уг уулзалтаар “Агро Мофа” ХХК нь Монгол Улсад Япон технологиор тосны ургамал тариалах, тариалалтад шаардагдах тосны ургамлын үрийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан тариаланчдад нийлүүлэх, хураасан тосны ургамлыг биржийн арилжаанд оролцуулан Япон Улс руу экспортлох талаар мэдээлэл өгч, санал солилцсон.

➤ Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарын тушаалаар байгуулагдсан “Экспортыг нэмэгдүүлж, худалдааг дэмжих” ажлын хэсгийн анхны хурал Эдийн засгийн хөгжлийн яаманд боллоо. Ажлын хэсгийг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал ахалж байгаа бөгөөд тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Отгонбаяр хамрагдан ажиллаж байна.

➤ Биржийн арилжааны спот гэрээний худалдах, худалдан авах гэрээ, биржийн итгэмжлэл олгох агуулах итгэмжлэлийн гэрээ, байнгын болон байнгын бус гишүүний гишүүнчлэлийн гэрээг тус тус цахимжуулах зорилгоор “Смарт Контракт Монголиа” ХХК нь иргэн, байгууллага, төр өөр хоорондоо бүхий л баримт бичгийг 100 хувь цахим хэлбэрээр үүсгэх, илгээх, баталгаажуулах, түүнийгээ блокчэйн сүлжээнд найдвартай хадгалах боломжтой E-Geree.mn цахим гэрээний системийг хөгжүүлсэн компанитай цахим уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтын үр дүнд гэрээнүүдийг цахимжуулах боломжийг тодорхойлсон бөгөөд 1 сарын хугацаанд Хөдөө аж ахуйн бирж цахим гэрээ үүсгэхэд E-Geree.mn-ийг ашиглан туршилт хийхээр шийдвэрлэж, үр дүн амжилттай болсон тохиолдолд цаашид гэрээг бүрэн цахимжуулан ажиллахаар тохиролцлоо. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь “Смарт Контракт Монголиа” ХХК хамтран ажилласнаар биржийн харилцагч иргэн, аж ахуйн нэгж хооронд байгуулах бүхий л гэрээг цахим хэлбэрээр үүсгэх, илгээх, баталгаажуулах, түүнийгээ блокчэйн сүлжээнд найдвартай хадгалах боломжтой болох юм.

➤ Австралийн Олон Улсын “Хөдөө аж ахуйн хөгжлийн төв”-ийн судлаачид “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцох уулзалт боллоо. Тус байгууллага нь Монголын ХАА-н салбарын бодлого, хөтөлбөрийн

хүрээнд судалгаа хийх бөгөөд цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцлоо.

➤ Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк, Ногоон уур амьсгалын сан, Европын хөрөнгө оруулалтын банк нарын хамтарсан Монгол Улсад хэрэгжиж буй “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр-ASDIP”-тай цахим уулзалт хийж, хамтран ажиллах талаар санал солилцлоо. Уулзалтаар малын гаралтай түүхий эдийн салбарын тулгамдсан асуудлууд болон ирээдүйн хамтын ажиллагааны боломжуудыг өргөн хүрээнд хэлэлцэв. Үүнд:

- Тогтвортой нийлүүлэлт: Малчид болон хоршоодын оролцоог нэмэгдүүлж, тэдний чадавхыг сайжруулах замаар малын гаралтай түүхий эдийн тогтвортой нийлүүлэлтийг хангах.
- Чанар, стандарт, үнэ: Түүхий эдийн чанар, стандартыг дээшлүүлж, стандарт, шаардлага хангасан түүхий эдийг нийлүүлснээр зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх.
- Зах зээлд нэвтрэх боломж: Малчид болон хоршоодын малын гаралтай түүхий, бүтээгдэхүүнийг зах зээлд нээлттэй борлуулах нөхцөлийг бүрдүүлэхэд уулзалт, үзэсгэлэн зохион байгуулах. Худалдагч болон худалдан авагчдыг холбосон, түүхий эдийн зах зээлийг илүү ил тод, үр дүнтэй болгох зорилготой “Малын гаралтай түүхий эдийн платформ” системийг бий болгох.

➤ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтыг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан зохион байгуулах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Худалдан авалтын ахлах мэргэжилтэн Б.Батчимэгтэй уулзалт хийж мэдээлэл, зөвлөгөө авлаа. Уулзалтын хүрээнд аймгийн хэмжээний боловсролын байгууллагууд (ЕБС, СӨБ)-ын хүнсний (мах, ногоо болон бусад хэрэглээний) хэрэгцээ, жилийн хэрэглээний хэмжээ, тоон мэдээлэл, судалгааг боловсруулах талаар санал солилцлоо.

➤ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авалт хийх тендер шалгаруулалтад шалгарсан аж ахуй нэгж, иргэнийг Татвараас хөнгөлөх, чөлөөлөх боломжийг эрэлхийлэн Дархан-Уул аймгийн Татварын газрын дарга Б.Жамсранжавтай уулзалт хийв. Уг уулзалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад оролцож байгаа аж ахуй нэгж иргэн нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх тухай хэсгийн “13.1.29. Малчдын хоршоо, малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр” үндэслэн татвараас чөлөөлөгдөх эрх үүссэн байна.

➤ 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдөр “Эрчист Монгол” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Амартүвшингээр ахлуулсан ажлын хэсэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ажиллалаа. Ажлын хэсэг нь яамны багцад хамаарах төрийн өмчит компаниудын үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл солилцлоо.

➤ "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-ыг мөрдөх, 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн мал, махыг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан эдийн засгийн эргэлтэнд оруулах арилжааг зохион байгуулах талаар ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнсний үйлдвэрийн бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газар, Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ын удирдлагууд цахим уулзалт хийж, Хөвсгөл аймагт амьд малын дуудлага худалдааг зохион байгуулахаар тогтон бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

➤ “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд арьс, ширний бэлтгэн нийлүүлэлтийн чанар, стандартыг сайжруулах талаар сургалт зохион байгуулах асуудлаар ХХААХҮЯ, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо” ТББ, “Мон-Ирээдүй” ХХК хамтарсан цахим уулзалт зохион байгуулж, тус арга хэмжээг 10 дугаар сард Хангайн бүс, Хойд бүс, Төвийн бүсүүдэд зохион байгуулахаар товллоо.

➤ Зүүн болон баруун аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдагуудтай өвс, хадлан, тэжээлтэй холбоотойгоор бэлчээрийн хазайлттай танилцаж, хэрхэн тэнцвэржүүлэн зохицуулалт хийж арилжаалах талаар цахим уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар өвс, хадлан, тэжээлийн зах зээлийн судалгаа, худалдан авах болон зарах талуудын үнэ, тоо хэмжээ, тээврийн нөхцөлийн талаар мэдээлэл судалгааг гаргаж, бэлтгэл ажлыг хангахаар тогтлоо.

➤ “Монгол тээвэр нэгдэл” ХХК-ийн ТУЗ дарга болон Гүйцэтгэх захиралтай Хөдөө аж ахуйн биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах боломжийн талаар цахим уулзалт хийлээ. Тус уулзалтаар талууд эхний ээлжинд өвс болон малын дотоодын арилжаанд туршилтын тээвэрлэлтийн үйл ажиллагааг явуулахаар тохиролцлоо.

➤ “Enomad” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцох уулзалт хийлээ. Тус компани нь хөдөө аж ахуйн салбарыг цахимжуулах, дэд бүтэц бүхий технологийн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Энэхүү уулзалтаар цаашдын хамтын ажиллагааны цар хүрээг тодорхойлох, хөдөө аж ахуйн салбарт менежментийн шинэчлэл хийх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцлээ.

Архив, албан хэрэг хөтлөлт:

➤ Байгууллагын үйл ажиллагааг баримтжуулах явцад цаасан болон цахим хэлбэрээр үүссэн захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл-лавлагааны баримт бичгийг зохион бүрдүүлэх, түүний хуулийн хүчинтэй байдлыг хангах, хадгалах, ашиглах, архивт шилжүүлэхэд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, MNS 5140:2021 стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байна.

➤ Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үйлчилгээг хууль, журмын дагуу хийж, албан хэрэг хөтлөлт, бичиг баримтын эргэлт, шийдвэрлэлт, хадгалалт, хамгаалалтад байнгын хяналт тавин ажиллаж байна.

➤ Тайлант хугацаанд компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 72, хүний нөөцтэй холбоотой тушаал 33, мөн 301 албан бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, заавар, журмын дагуу албажуулж, гадны байгууллагаас ирүүлсэн 175 бичиг, 20 өргөдөл хүлээн авч бүртгэн, удирдлагын цохолтоор хэлтсүүдэд хуваарилан хариуг гаргуулан, бүртгэл хяналтын карт хөтөлж ажиллалаа.

1.7. Маркетинг:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны хагас жилийн тайланг цахим сэтгүүл болгож вебсайт дээр байршуулсан ба 2025 оны маркетингийн төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.
- Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, цахим хуудсыг хөгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын албан ёсны цахим хуудсыг долоо хоногийн календарчилсан системтэйгээр хөгжүүлж байна. Үүнд:
 - Даваа гарагт: Долоо хоногийн арилжааны мэдээ
 - Мягмар гарагт: Биржийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл
 - Лхагва гарагт: Бусад мэдээлэл (салбарын хүрээнд)
 - Пүрэв гарагт: Үрийн болон хүнсний улаанбуудайн арилжааны мэдээ
 - Баасан гарагт: Цаг үеийн мэдээ, онцлох мэдээ байдлаар календарчилан бэлтгэн нийтэлж байна.

Эдгээр календарчилсан мэдээ, мэдээллүүдийг түгээхээс гадна тухайн өдрийн цаг үеийн шинжтэй мэдээ, арилжааны мэдээ, онцлох үйл явдал, салбарын мэдээ, инфографик зэрэг мэдээ мэдээллүүдийг цаг алдалгүй түгээж ажилласан.




- Компанийн долоо хоног тутмын арилжааны мэдээг Bloomberg TV-ийн мэдээний буланд байршуулж олон нийтэд түгээн ажиллалаа. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэвлэл мэдээлэлтэй хамтран 7 хоног бүр компанийн онцлох үйл явдлын мэдээг тоймлон яамны сувгаар дамжуулан хүргэж байна.
- Тайлант хугацаанд компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 1,894,410 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 хувиар өссөн байна. Мөн цахим хуудасны зочилсон хэрэглэгчдийн тоо 32,822 байгаа нь мөн үетэй харьцуулбал 16.2 хувиар өссөн. Энэхүү үзүүлэлт нь цэвэр органик өсөлт бөгөөд нэмэлт төлбөртэй мэдээ байршуулалгүйгээр нэмж чадсан байна.

Цахим хуудасны статистик мэдээ



Цахим хуудасны анализ

2025 он 2024 он 2023 он



Өмнөх оны мөн үетэй харьцуулбал



- Компанийн вебсайтын нүүр хэсэг, баннерын загварыг шинэчилж, цахим гарын авлага, тайланг бэлтгэн оруулж, үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдаа руу шууд нэвтрэх цонх үүсгэн вебсайтын бүтцийг шинэчилж, цаг үеийн мэдээ, мэдээллүүдийг тухай бүр байршуулан олон нийтэд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар мэдээллийг шуурхай хүргэн ажиллаж байна.
- Компанийн үүдний лобби хэсэгт байрлах дэлгэцэн дээр компанийн үйл ажиллагааны танилцуулга видео, үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдаанд хэрхэн оролцох арга зүйн видео, үрийн буудайн үнийн мэдээлэл, бүтээгдэхүүний танилцуулга зэрэг видео контент хийж гүйцэтгэсэн.
- Компанийн мэдээ, мэдээллийг зурган контентоор хүргэх зорилгоор инстаграм платформд шинээр профайл үүсгэн хөгжүүлж ажиллаж байгаа бөгөөд твиттер профайлыг хөгжүүлэхээр шинээр хаяг үүсгэсэн. Мэдээ, мэдээллийг 2025 оны II дугаар улирлаас эхлэн компанийн албан ёсны цахим сүлжээний 4 сувгаар /фейсбүүк, твиттер, вебсайт, инстаграм/ түгээн хөгжүүлж байна.
- Компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, олон нийтэд түгээх зорилгын хүрээнд МҮОНРТ-тэй хамтран 2 удаагийн нэвтрүүлэг хийгдэж байгаагаас “Ухаалаг


хөдөө аж ахуй” сэдэвт 29 минутын нэвтрүүлэг бэлтгэгдэж МҮОНРТ болон цахим хуудсаар түгээн, хүргэсэн байна.

➤ 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэвлэмэл гарын авлага, зөвлөмж зэргийг дижитал хэлбэрт шилжүүлэн И-Брошур болгон хийж гүйцэтгэн цахим хуудас болон вебсайтад байршуулсан. Энэ нь хэвлэмэл материалыг дижитал форматтай болгож олон нийтэд шууд гар утас, таблет, компьютерээс байгууллагын хэвлэмэл мэдээлэл, танилцуулгыг үзэх боломжтой болгосон. Үүнд:

- Клиринг, төлбөр тооцооны зөвлөмж
- Клиринг, төлбөр тооцооны зөвлөмж гарын авлага
- Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны гарын авлага
- Ноолуур бэлтгэх арга гарын авлага
- Компанийн 2024 оны жилийн эцсийн тайлан
- Ноос хяргах, бэлтгэх гарын авлага
- Тэмээний ноос бэлтгэх гарын авлага
- Компанийн үндсэн танилцуулга
- Компанийн 2025 оны хагас жилийн тайлан
- Амьд малын төвлөрсөн арилжааны танилцуулга
- Малчид, хоршоодод зориулсан танилцуулга



<https://online.fliphtml5.com/vevse/vwxt/> <https://online.fliphtml5.com/vevse/dewi/> <https://online.fliphtml5.com/vevse/jkn/>



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК | ЭНХТЭЙВНИЙ ӨРГӨН ЧӨЛӨӨ, 18А-1, МХААХҮҮХ БАЙР, 2 ДАВХАРТ

<https://online.fliphtml5.com/vevse/vovb/>




<https://online.fliphtml5.com/vevse/sbqn/>



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК | ЭНХТЭЙВНИЙ ӨРГӨН ЧӨЛӨӨ, 18А-1, МХААХҮҮХ БАЙР, 2 ДАВХАРТ

<https://storage2.me-qv.com/pdf/d6d5a388-940e-49f5-9690-0fa5f54f6ec8.pdf>



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК | ЭНХТЭЙВНИЙ ӨРГӨН ЧӨЛӨӨ, 18А-1, МХААХҮҮХ БАЙР, 2 ДАВХАРТ

<https://storage2.me-qv.com/pdf/cb8283d8-eb71-4308-8ab1-eb41c60cbd20.pdf>



ХӨДӨӨ АЖ
АХУЙН БИРЖ
ТӨХХК



<https://online.fliphtml5.com/vevse/bfvc/>

<https://online.fliphtml5.com/vevse/nxyn/>

➤ Цахим хуудсаар дамжуулан ирсэн санал, хүсэлт, гомдлыг холбогдох мэргэжилтнүүдэд өгч тухай бүр хэрэглэгчдэд хариу өгсөн. Нийт 71 зурвас ирсэн бөгөөд бүгд мэдээлэл авах, хоршоонд хэрхэн элсэх, биржээр хэрхэн арилжаанд оролцох талаар асуусан ба эдгээр асуултад цаг алдалгүй хариу өгч ажилласан байна.

Мөн Дархан-Уул аймагт шилжин ирсэнтэй холбогдуулан дэлгэцэн дээр байршуулах loop video /богино хэмжээний видео/ бэлтгэсэн. Үүнд:

- Биржийн тухай товч танилцуулга
- Улаанбуудайн үнийн мэдээлэл
- Үрийн буудайн үнийн мэдээлэл
- Үрийн буудайн танилцуулга
- Demo бичлэг

➤ Ноолуурын бэлтгэлийг хангуулах, үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр түүхий эд худалдан авалтын санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, түүнийг мөнгөжүүлэх ажлын хүрээнд дөрвөлсөн гэрээний төслийг боловсруулах, санал өгөх, ppt танилцуулга, вексель бичигч үйлдвэрүүдэд векселийн үнэт цаас дээр бичилт хийх гарын авлагыг брошур болон зурган хэлбэрээр хийж гүйцэтгэсэн.

Вексель дамжуулан бичих заавар, зөвлөмж

1. Вексель эзэмшигч буюу малчин өөрийн нэрийг бичнэ;
2. Вексель мөнгөжүүлсэн банкны нэр бичнэ;
3. Вексель мөнгөжүүлсэн банкны дансны дугаарыг бичнэ;
4. Вексель мөнгөжүүлж буй банкны нэр, хаягыг бичнэ;
5. Векселийг мөнгөжүүлэх огноог бичнэ;
6. Малчин өөрийн нэр, гарын үсгийг зурна;

Вексель мөнгөжүүлэх санамж

Векселийг бүрэн бүтэн байдлыг ханган банканд тушааж мөнгөжүүлнэ. Үүнд:

- ❗ Худалдан борлуулсан бараа, түүхий эдийг үйлдвэрийн агуулахад хүлээн авч, векселийг банканд очиж мөнгөжүүлэх эрх үүсэх тул тодорхой хугацаа шаардагдана /энэ хугацааг үйлдвэр тодорхойлж мэдээлэх үүрэгтэй/;
- ❗ Векселийг нугалахгүй, үрчилгэхгүй, норгохгүй, гэмтээхгүй байх;
- ❗ Векселийг хаяж гээгдүүлэхгүй байх /хаяж, гээгдүүлсэн тохиолдолд даруй үйлдвэртээ хандаж мэдэгдэнэ/;
- ❗ Вексель нь үнэт чанар болох үрчийсэн, норсон, гэмтсэн тохиолдолд хүчингүй болохыг анхаарна уу;
- ❗ Векселийг мөнгөжүүлэхэд өөрийн бичиг баримтыг векселийн хамт банканд авч очино;

Бидэнтэй холбогдох

- www.mce.mn
- 70148779, 70138779
- Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК
- Дархан-Уул аймгийн Дархан сум, 14 дүгээр баг, Олимпын-3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 1 дүгээр давхар, Монгол Улс.




➤ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд бэлтгэл ажлыг ханган амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллалаа.

➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, харьяа агентлагуудын хамт олон Дархан-Уул аймгийн Дархан сумын 14-р багийн нутаг дэвсгэрт орших Бурхантын гудамжинд 240 ширхэг нарс мод, 250 ширхэг голт бор бут тарьж, гудамж талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажилд оролцсон.


Цахим хуудсанд тайлант хугацаанд нийт 451 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж ажилласан байна. Үүнд:

- Сарын онцлох үйл явдлын тойм видео мэдээ
- Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдаанд хэрхэн оролцох заавар видео
- Дуудлага худалдааны системд бүртгүүлэх заавар видео
- Мал, махны төвлөрсөн зарын сайтын танилцуулга, заавар видео
- Цаг үеийн холбогдолтой видео рийлс мэдээ
- Постер мэдээ
- Инфографик мэдээ
- Цахим гарын авлага
- Зурагт мэдээ
- Мал, махны дуудлага худалдааны сурталчилгааны шторк видео
- Видео мэдээг тус тус нийтэлсэн байна.

2025 оны цахим хуудасны хандалтын тоо



2025 оны сарын дундаж цахим хуудасны хандалтын тоо



ХОЁР. АРИЛЖАА


2.1. Түүхий эдийн арилжаа

Тайлант хугацаанд 164 удаагийн цахим арилжаа зохион байгуулж, 681 хэлцлээр 1,039.6 тэрбум төгрөгийн үнэ түүхий эдийн арилжаа зохион байгуулсан байна.

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны тодотгосон төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү
	<u>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</u>				
	а) Арилжааны хэмжээ	тонн	28,008.00	125,768.51	(97,760.51)
1	Ноолуур /самнасан/	тонн	3,000.00	3,258.00	258.00
	Хонины ноос	тонн	8,257.00	4,240.00	(4,017.00)
	Тэмээний ноос	тонн	934.00	1,006.60	72.60
	Ямааны завод ноос	тонн	2,192.00	1,956.49	(235.51)
	Хонины завод ноос	тонн	30.00	-	(30.00)
	Тосны ургамал	тонн	5,495.00	5,849.00	354.00
	Мал бэлтгэл /толгой/	амьд мал	6,000.00	2,142.00	(3,858.00)
	Мах бэлтгэл /гулууз/	тонн	100.00	96.00	(4.00)
	Үрийн буудай	тонн	1,000.00	12,011.30	11,011.30
	Хүнсний буудай	тонн	1,000.00	95,209.12	94,209.12
	Малын тэжээл	тонн	-	14.00	14.00
	Арьс шир	ширхэг	-	4,825.00	4,825.00
	б) Арилжааны дүн	тэрбум.төг	804.19	1,154.83	(350.64)
2	Ноолуур	тэрбум.төг	714.00	963.37	249.37
	Хонины ноос	тэрбум.төг	14.99	9.77	(5.22)
	Ямааны завод ноос	тэрбум.төг	46.69	41.58	(5.11)
	Тэмээний ноос	тэрбум.төг	8.98	14.98	6.00
	Хонины завод ноос	тэрбум.төг	0.03	-	(0.03)
	Тосны ургамал	тэрбум.төг	8.90	9.93	1.03
	Мал бэлтгэл /толгой/	тэрбум.төг	0.45	-	1.05
	Мах бэлтгэл /гулууз/	тэрбум.төг	7.50	1.50	(7.50)
	Үрийн буудай	тэрбум.төг	1.50	19.00	17.50
	Хүнсний буудай	тэрбум.төг	1.15	94.70	93.55
	Малын тэжээл	тэрбум.төг	-	0.03	0.03
	Арьс шир	тэрбум.төг	-	0.10	0.10

Арилжсан бараа, түүхий эдийн хэмжээ, дүн

1,039.6 тэрбум



Тайлант хугацаанд биржээр арилжаанд оролцсон 5 брокерын компанийн 71 аж ахуйн нэгжид 839 ширхэг “Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт”-ыг олгосон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын дагуу “Арилжааны мэдээ”-г бэлтгэн Санхүүгийн зохицуулах хороонд сар бүр хүргүүлэн ажиллаж байна.

2.2. Хүнсний улаанбуудайн арилжаа

Тайлант хугацаанд нийт 94.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 95,209.12 тонн хүнсний улаанбуудайг дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжсан.

Хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны мэдээ

№	Улаанбуудайн төрөл	Хэмжээ, тонн	Нийт үнэ
1	2021 оны 1 ангилал	85.19	92,431,150.00
2	2022 оны 3 ангилал	930.2	953,455,000.00
3	2022 оны 4 ангилал	3756.93	3,483,519,550.00
4	2023 оны 1 ангилал	133.36	160,698,800.00
5	2023 оны 2 ангилал	489.15	540,510,750.00
6	2023 оны 3 ангилал	7,086.80	5,239,404,000.00
7	2023 оны 4 ангилал	13,092.05	12,175,606,500.00
8	2024 оны 1 ангилал	5,089.93	6,133,365,650.00
9	2024 оны 2 ангилал	6,430.76	7,298,962,600.00
10	2024 оны 3 ангилал	15,096.42	16,228,651,500.00
11	2024 оны 4 ангилал	17,804.55	17,052,254,250.00
12	2025 оны 4 ангилал	25,213.78	25,314,262,000.00
Нийт		95,209.12	94,673,121,750.00

2.3. Үрийн улаанбуудайн арилжаа

2025 оны хаврын тариалалтад шаардагдах үрийн улаанбуудайн дуудлага худалдааг www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжиж байгаа бөгөөд тус дуудлага худалдааг 7 хоногийн Даваа, Мягмар, Пүрэв гаригуудад зохион байгуулсан. Дуудлага худалдаагаар дараах сортын үрийн улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр арилжаад байна. Үүнд:

Тайлант хугацаанд 9 сортын 12,011.3 тонн үрийн улаанбуудайг арилжсан ба дуудлага худалдааны арилжааны үнийн дүн 19.0 тэрбум төгрөг байна.

Үрийн улаанбуудайн дуудлага худалдааны мэдээ

№	Улаанбуудайн төрөл	Хэмжээ, тонн	Үнийн дүг
1	Бурятская остистия	5,303.00	8,719,945,000.00
2	Дархан 144	2,129.00	3,488,110,000.00
3	Дархан 193	50.00	93,275,000.00
4	Алтайская 70	1,921.60	2,977,815,000.00
5	Алтайская 75	70.00	106,750,000.00
6	Алтайская 325	977.10	1,385,287,500.00
7	Юнион	464.60	644,955,000.00
8	Гонец	996.00	1,499,350,000.00
9	Ирень	100.00	152,575,000.00
Нийт		12,011.30	19,068,062,500.00

Үрийн болон хүнсний улаанбуудайн арилжааг дуудлага худалдааны системээр 102 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 110 аж ахуйн нэгж, иргэн оролцсон байна.

2.3. Тосны ургамал /рапс/ импортын үрийн арилжаа

Импортоор оруулж ирсэн 2025 оны хаврын тариалалтад шаардагдах тосны ургамал /рапс/-ын үрийн дуудлага худалдааг www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжсан. Дуудлага худалдаагаар дараах сортын рапсын үрийг Хөдөө аж ахуйн биржээр арилжаад байна. Үүнд:

Тосны ургамал /рапс/-ын дуудлага худалдааны мэдээ

№	Тосны ургамал /рапс/-ын үрийн төрөл	Хэмжээ, тонн	Үнийн дүн
1	Чинза-5, Чинза-7 /хар/	112.1	2,691,600,000.00
2	Жинюү-6 /шар/	78	507,000,000.00
	Нийт	190.1	3,198,600,000.00

Тосны ургамал /рапс/-ын импортын үрийн дуудлага худалдаанд давхардсан тоогоор 81 аж ахуйн нэгж, иргэн оролцсон байна.

2.4. Мал, махны арилжаа

“Ашид мөнх баян” хоршооны 273 сая төгрөгийн 26 тонн хонины гулууз мах, 130 сая төгрөгийн 10 тонн үхрийн махны дуудлага худалдааг амжилттай зохион байгууллаа. Энэхүү дуудлага худалдаанд "Сочо шимт" ХХК ялагч болж худалдан авалтыг хийсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 02/1834 дугаар албан бичгийн хүрээнд Малын удмын сангийн үндэсний төвийн хээлтэгч малын дуудлага худалдааг Сүхбаатар аймаг, Дорнод аймгуудад зохион байгуулахаар Гүйцэтгэх захиралын 2025 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн А/31 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Малын удмын сангийн үндэсний төвийн Сүхбаатар, Дорнод аймгуудад ажиллаж 192 толгой хонины 31.4 сая төгрөгийн дараах малын арилжаа, дуудлага худалдааг зохион байгууллаа. Үүнд:

- Сүхбаатар аймагт байгаа хургатай хонь – 41, сувай эм хонь – 27, ишигтэй ямаа – 27, сувай эм ямаа – 17 толгой малын дуудлага худалдааг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Сүхбаатар аймгийн Хөдөө аж ахуйн газрын хурлын танхимд зохион байгууллаа. Уг дуудлага худалдаанд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар, малчин М.Анхбаяр нар оролцож үнэ өсөх зарчмаар оролцлоо. Харилцан үнийн санал илгээж малчин М.Анхбаяр ялагч болж 18.4 сая төгрөгөөр худалдан авч форвард гэрээ байгууллаа.
- Дорнод аймгийн Булган суманд байгаа Малын удмын сангийн үндэсний төвийн хуц – 2, эр хонь -2, хургатай эм хонь – 25, сувай эм хонь -51 толгой малын арилжааг 2025 оны 07 дугаар сарын 08-ний өдөр онлайнаар зохион байгууллаа. Уг дуудлага худалдаанд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын малчин М.Анхбаяр дахин ялагч болж 13.0 сая төгрөгөөр худалдан авч төлбөр төлөх хугацаа болон мал хүлээлгэн өгөх хугацаагаа тохирон форвард гэрээ байгууллаа.
- Увс аймгийн Сагил суманд Малын удмын сангийн үндэсний төвийн 32.7 сая төгрөгийн 400 толгой хонины дуудлага худалдааг 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр танхимаар зохион байгууллаа.

Гойд ашиг шимт малын “Шилмэл мал - 2025” үзэсгэлэн, дуудлага худалдаа 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Малын удмын сангийн үндэсний төв”-ийн байранд 36 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Тус дуудлага худалдаагаар Араб, Англи азаргийг 47 сая төгрөгөөр, “Герефорд” үүлдрийн 2 толгой бухан бярууг 18 сая төгрөгөөр тус тус арилжлаа.

Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаанаас Дорнод аймагт байрлах бүсэд бүртгэлтэй 55 толгой үхэр биржээр дамжуулан худалдан борлуулахад хамтран ажиллах санал ирсэний дагуу 2025 оны 11 дүгээр сарын 03-07-ний өдрүүдэд тус аймагт ажиллаж, биржийн дуудлага худалдааны системээр дамжуулан арилжааг зохион байгуулсан. Дуудлага худалдааны ялагчаар “Чойбалсан групп” ХХК шалгарч 47.6 сая төгрөгийн худалдан авалт хийлээ.

Уур амьсгалын ногоон сан Green Climate Fund-ийн санхүүжилтээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон UNDP in Mongolia - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь - АДАПТ төсөл”-өөс зарласан баруун болон зүүн бүсийн “Мал, махны дуудлага худалдаа”-г зохион байгуулах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцож, шаардагдах бичиг баримтын бүрдэлийг ханган хүргүүлж шалгарсан. Малчдын бэлтгэсэн гарал үүсэл тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан, үйлдвэрийн чанарын шаардлагад нийцсэн мал, махыг зах зээлд борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилго бүхий баруун болон зүүн бүсийн “Мал, махны дуудлага худалдаа”-г Завхан аймгийн Улиастай суманд, Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд тус тус амжилттай зохион байгууллаа. Үүнд:

- Баруун бүсийн дуудлага худалдаа Завхан аймгийн Улиастай суманд 2025 оны 11 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Дуудлага худалдаагаар Улиастай сумын Богдын гол багын Х.Болд 8 толгой бух, Завхан аймгийн Алдархаан сумын малчин Э.Батсүх 300 толгой ямаа, Завхан аймгийн Алдархаан сумын малчин Н.Давааням 230 толгой ямаа, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын малчин Б.Рахинжан 20 тонн ямааны мах, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын малчин Д.Далихан 40 тонн үхрийн мах тус тус арилжаалагдаж, худалдан авагчаар “Энх хүслийн ундраг” дундын хоршоо, “Бадар хундага оргил” ХХК тус тус шалгаран нийт 765.3 мянган төгрөгийн арилжаа хийгдсэн байна.
- Зүүн бүсийн дуудлага худалдаа Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд 2025 оны 12 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Дуудлага худалдаагаар Сүхбаатар аймгийн Асгат сумын малчин Б.Отгонбаатар 21 толгой адуу, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын малчин Х.Сүхбаатар 103 толгой хонь, 102 толгой ямаа, Дорнод аймгийн Халхгол сумын малчин З.Батбаяр 643 толгой хонь, Малын удмын сангийн үндэсний төвийн 139 толгой хурган хуц, эм хонийг тус тус арилжаалагдаж, худалдан авагчаар “Дорнод мах маркет”ХХК, “Баян тал” ХХК тус тус шалгаран нийт 173.5 сая төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.5. Арьс, ширний арилжаа

“Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдсан “Арьс ширэн түүхий эд бэлтгэлийн хэлэлцүүлэг 2025” арга хэмжээний

хүрээнд 204.8 сая төгрөгийн 6579 ширхэг арьс, ширний дуудлага худалдааг зохион байгууллаа. Үүнд:

- Төвийн болон Хойд бүсэд хийгдсэн дуудлага худалдаагаар “Дархан Эрдэнэ мах комбинат” ХХК-ийн 500 ширхэг үхрийн ширийг “Булигаар” ХК худалдан авав.
- Хангайн бүсэд хийгдсэн дуудлага худалдаагаар 200 ширхэг үхрийн шир, 20 ширхэг ямааны арьсыг тус тус “Мон ирээдүй” ХХК, 20 ширхэг үхрийн ширийг “Булигаар” ХК худалдан авав.
- Хөвсгөл аймагт хийгдсэн дуудлага худалдаагаар 20 ширхэг Суффолк үүлдэрийн хонины нэхий, 20 ширхэг Мерино үүлдэрийн хонины нэхийг тус тус “Дархан нэхий” ХК худалдан авав.
- 2025 оны 12 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан цахим дуудлага худалдаагаар Архангай аймгийн Хотонт сумын “Шинэ бургалтай” хоршооны бэлтгэсэн 1204 ширхэг үхрийн шир, 4595 ширхэг ямааны ноолууртай арьсыг тус тус “Мон ирээдүй” ХХК худалдан авав.

“Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдсан “Арьс ширэн түүхий эд бэлтгэлийн хэлэлцүүлэг 2025” арга хэмжээнд дараах аж ахуйн нэгжүүд оролцов. Үүнд:

- Ерөнхийлөгчийн тамгын газар;
- Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- “Хөдөө аж ахуйн бирж” ХХК;
- Зээлийн батлан даалтын сан,
- Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар;
- Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- “Цагаан алт” ТББ;
- “Монголын арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн холбоо” ТББ;
- “Дархан нэхий” ХК;
- “Булигаар” ХК;
- “Мон ирээдүй” ХХК;
- “Арилдий” ХХК тус тус оролцлоо.

2.6. Малын тэжээлийн арилжаа

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/164 дугаар тушаалын ажлын хэсэгт хамрагдаж, Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Баян булагтай сант” хоршоо, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын “Бумбат таван богд” хоршоодтой малын тэжээлийн туршилтын арилжааг амжилттай зохион байгуулж нийт 25.8 сая төгрөгийн 14 тонн хэмжээ бүхий “Малын тэжээлийн форвард” гэрээг байгуулав.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайлант хугацаанд нийт 681 хэлцлийн худалдах, худалдан авах гэрээг баталгаажуулж, 1,039.6 тэрбум төгрөгийн спот гэрээний төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна.

Биржийн төлбөр тооцооны дүн, /сая төгрөг/

	2021	2022	2023	2024	2025
Дебит	794,561.72	1,110,401.27	968,432.25	996,870.64	1,039,633.4
Кредит	794,561.72	1,110,401.27	968,432.25	996,870.64	1,039,633.4

Тайлант хугацаанд нийт 22.3 тэрбум төгрөгийн дэнчин, 121.6 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийн гүйлгээг программд шивж байршуулан арилжааны бэлтгэлийг ханган ажилласан ба клиринг, төлбөр тооцооны аливаа эрсдэл гараагүй, төлбөр тооцоо хугацаандаа хийгдсэн болно.

Дэнчин, барьцаа, худалдах, худалдан авах гэрээтэй холбогдох бичиг баримтыг бүртгэлжүүлэх, хянах, хадгалах, гүйлгээг хураангуйлах, өдрийн эцэст тайлан гаргах, нэгтгэх зэрэг клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагааг өдөр тутам зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд харилцах данснуудын журналыг сар, улирлаар нэгтгэн гаргаж байна.

Гурилын үйлдвэрүүдэд нийлүүлэх хүнсний улаанбуудай болон 2025 оны хаврын тариалалтад шаардагдах үрийн улаанбуудайг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжиж эхэлсэнтэй холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2024 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан “Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдааны түр журам”-д зааснаар дэнчин болох худалдан авалтын үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг биржийн Хаан банкн дах биржийн клирингийн дансанд байршуулан дуудлага худалдааны ялагчийн хүсэлтийг үндэслэн “Худалдах, худалдан авах гэрээ”-ний төлбөрийн үүргийг тус дэнчингээр хангуулах боломжоор ханган ажиллаж байна.

2025 оны намрын ургац хураалтаас хүнсний болон үрийн улаанбуудайн арилжааг дуудлага худалдааны системээр зохион байгуулж, хэлцлийг худалдах, худалдан авах форвард гэрээгээр баталгаажуулахаар шийдвэрлэн “Хүнсний болон үрийн улаанбуудайн худалдах, худалдан авах форвард гэрээ”-ний загварыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/46 дугаар тушаалаар баталлаа.

Малын тэжээлийн дотоодын арилжааг идэвхжүүлж эхэлсэнтэй холбогдуулан “Худалдах, худалдан авах форвард гэрээ”-ний загварыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталлаа.


Арьс, ширний арилжааг идэвхжүүлж эхэлсэнтэй холбогдуулан арьс, шир “Худалдах, худалдан авах форвард гэрээ”-ний загварыг боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/58 дугаар тушаалаар, дотоодын арьс, ширний дуудлага худалдаа зохион байгуулагдаж буйтай холбогдуулан “Худалдах, худалдан авах дуудлага худалдааны спот гэрээ”-ний загварыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 12-ны А/72 дугаар тушаалаар тус тус баталлаа.

ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛ, БҮРТГЭЛ

4.1. Биржээр арилжаалах бараа, түүхий эдийн хяналт, бүртгэл

Тайлант хугацаанд биржийн итгэмжлэл авч "Итгэмжлэл олгох гэрээ" байгуулсан орон нутаг дахь түүхий эдийн агуулахуудад бичиг баримтын шалгалт хийж, бичиг баримтын зөрчилтэй болон гэрээний хүчинтэй хугацаа дууссан агуулахуудын гэрээг дүгнэж, итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлийг шинэчилсэн. 2025 онд үйлдвэрийн дэргэдэх 20 агуулах, орон нутгийн 4 агуулах биржтэй "Агуулахын итгэмжлэлийн гэрээ" байгуулан хамтран ажиллаж байна.

Агуулахын удирдлагын системд бүртгүүлсэн бараа, түүхий эдийн хэмжээ, хувь



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан "Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ыг мөрдөн ажиллах, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-тай байгуулсан санамж бичгийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд ноолуур, хонины ноос, завод ноосонд MNS ISO/IEC 17065:2013 стандартын дагуу баталгаажуулалтыг хийлгэж байна. 2025.06.17-12.31-ний өдрийн байдлаар 130 аж ахуйн нэгжийн 1933.5 тн хонины угаасан ноос, 1131.8 тн самнасан ноолуур, 130 тн завод ноосны баталгаажуулалт хийгдээд байна.

2025 он гарснаас хойш нийт 10 агуулахад хадгалагдаж буй бараа, түүхий эдийн биржийн арилжаанд оролцсон.

Санхүүгийн зохицуулах хорооны "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын дагуу "Биржийн итгэмжлэл

олгогдсон этгээдийн мэдээ"-г бэлтгэн Санхүүгийн зохицуулах хороонд сар бүр хүргүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж, ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ноолуурын бэлтгэлийг хангуулах, үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр түүхий эд худалдан авалтын санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, түүнийг мөнгөжүүлэх, эргэн төлүүлэхтэй холбогдсон асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ, Үндэсний үйлдвэр, Арилжааны банкууд хамтран ажиллаж байгаа бөгөөд векселийн харилцаанд оролцохоор хүсэлт ирүүлсэн 17 аж ахуйн нэгжийн векселиэр худалдан авалт хийсэн ноолуурыг хадгалах түүхий эдийн агуулахын чанар, эрүүл ахуй, үйл ажиллагаа, камержуулалт, тоног төхөөрөмж зэрэгт шалгалт хийж, үйлдвэрийн дэргэдэх 2 агуулахыг биржийн “Итгэмжлэгдсэн агуулахад тавих шалгуур үзүүлэлт”-ийг хангуулан итгэмжлэл олгоод байна. Хаан банк, Голомт банкууд векселийн харилцаанд оролцохоо илэрхийлж, 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр “Ханбогд кашимер” ХХК болон “Говь” ХХК-иудтай тус бүр 7 тэрбум төгрөг, нийт 14 тэрбум төгрөгийн санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг үзэглэлээ. Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцсон.

Япон Улсын агуулахын барилгын үйл ажиллагаа эрхлэгч “Озава тент” ХХК-тай Монгол орны цаг уур, байгаль орчны нөхцөл, улирлын чанартай бэлтгэгдэж буй түүхий эдийн хадгалалтын горим, шаардлагад нийцэх зохицлыг тодорхойлох зорилгоор малын гаралтай бараа, түүхий эдийг хадгалах тентен хийц бүхий түүхий эдийн агуулахыг Монгол Улсад туршин, нэвтрүүлэх тухай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2024 онд байгуулсан. Биржийн “Ложистикийн төв”-ийн хашаанд барих туршилтын агуулахын барилгын ажлыг эхлүүлэх талаар хэлэлцэхээр тус компанийн төлөөлөгчид 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Дархан-Уул аймагт Гүйцэтгэх захиралтай уулзалт хийсэн ба барилгын ажлыг 2025 оны 8 дугаар сараас эхлүүлж, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өглөө. Тус тентэн агуулах нь мембран материалыг ашиглан агаарын давхарга үүсгэх технологид суурилсан өндөр чанарын агуулах бөгөөд -40 градуст тэсвэртэй, барихад хялбар гэдгээрээ онцлогтой юм.

4.2. Гишүүнчлэл

Байнгын гишүүн:

Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/ болох “Хаан Тэлмэн” ХХК, “Ханбүргэд Хэнтий” ХХК, “Алтаншагай импекс” ХХК, “Цэц-Инвест” ХХК, “Бадархундага Оргил” ХХК, “Роял кашимер” ХХК-иуд биржтэй “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулан арилжаанд оролцож байна. “Суварга Алтай констракшн” ХХК нь “Гишүүнчлэлийн гэрээ” сунгаагүй тул арилжаанд оролцохгүй байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 5 байнгын гишүүн брокерын компани биржийн арилжаанд оролцсон. Үүнд:

- “Ханбүргэд Хэнтий” ХХК /0005/ - 113 удаа 272 хэлцлээр 454.3 тэрбум төгрөг;
- “Хаан Тэлмэн” ХХК /0008/ - 41 удаа, 193 хэлцлээр 147.3 тэрбум төгрөг;
- “Цэц-Инвест” ХХК /0010/ - 68 удаа 133 хэлцлээр 265.7 тэрбум төгрөг;
- “Алтаншагай импекс” ХХК /0031/ - 25 удаа 50 хэлцлээр 128.3 тэрбум төгрөг;
- “Бадархундага Оргил” ХХК /0001/ - 1 удаа 1 хэлцлээр 177.9 сая төгрөг.

Санхүүгийн зохицуулах хорооны “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ын дагуу “Биржийн арилжаанд оролцогчдын мэдээ”-г бэлтгэн Санхүүгийн зохицуулах хороонд сар бүр хүргүүлэн ажиллаж байна.

Байнгын бус гишүүн:

Байнгын бус гишүүний гэрээний хугацаа 1 жил байсантай холбогдуулан орон нутгийн агуулахын тоо буурах, жил тутам гэрээ шинэчлэн байгуулах нь хоршоодод хүндрэл, төвөгтэй байдал, санхүүгийн үр ашиггүй зардал гаргах зэрэг нөхцөлийг бий болгож байсан тул Гүйцэтгэх захирлын 2024 оны А/84 тушаалаар “Гишүүнчлэлийн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, гишүүнчлэлийн хугацааг 3 жил болгосон. Тайлант хугацаанд биржийн байнгын бус гишүүн оролцогчидтой байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-ний хэрэгжилтэд бичиг баримтын шалгалт хийж, бичиг баримтын зөрчилтэй болон гэрээний хүчинтэй хугацаа дууссан байнгын бус гишүүдийн гэрээг дүгнэж, байнгын бус гишүүдийн бүртгэлийг шинэчилсэн ба 30 хоршоо биржтэй “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулан хамтран ажиллаж байна.

“Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо”-ны гишүүн хоршоодыг чадавхжуулж, биржийн арилжаанд оролцуулах, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” ТББ-тай хамтран ажиллаж “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд үүсгэн байгуулагдсан хоршооны мэдээлэл авч ажиллаж байна.

ТАВ. ЦАХИМ ХӨГЖҮҮЛЭЛТ

5.1. Арилжаа, төлбөр тооцооны систем /cloud.mce.mn/

Тайлант хугацаанд экспортод чиглэсэн 164 удаагийн цахим арилжаагаар 681 хэлцэл, дотоодын арилжааг дуудлага худалдааны системээр дамжуулан 224 удаагийн арилжааг тус тус амжилттай зохион байгуулсан байна.

Мөн “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн арилжаа, төлбөр тооцооны системийг хариуцсан “Ай түүлс” ХК-ийн төлөөлөлтэй системийн өргөтгөл, хөгжүүлэлтийн талаар уулзалт хийж арилжаа, төлбөр тооцооны системийн 2025 оны ашиглалт үйлчилгээний дэмжих гэрээг байгуулсан. Арилжаа, төлбөр тооцооны системийн дундын өгөгдлийн санг шинээр үүсгэж Dbeaver-ээр ханддаг болсон.

5.2. Экспортын нэг цонхны систем /export.mofa.gov.mn/

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн “Экспортын нэг цонхны систем” /www.export.mofa.gov.mn/-ээр Мал эмнэлгийн ерөнхий газрын “Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ”-ний 5805 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн.

2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс тус системээр ургамал, үр тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний импортын мэдэгдэл, дамжин өнгөрөх мэдэгдэлийн хүсэлтийг, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мал, амьтны гаралтай түүхий эд үйлчилгээний бусад төрлүүд нэвтэрч эхэлсэн.

Тайлант хугацаанд импортын мэдэгдлийн гэрчилгээ 1953 ширхэг, дамжин өнгөрөх гэрчилгээ 1093 ширхэгийг шийдвэрлэгдсэн бөгөөд нийт 79 байгууллагад зөвлөгөө өгч, гадаад эзэнтэй 82 байгууллагын нэвтрэх эрх, компани төлөөлөх ажилтныг системд тохируулж өгсөн байна.

5.3. Биржийн мал, махны зарын систем /www.ariljaa.mce.mn/

Биржийн мал, махны зарын [ariljaa.mce.mn](http://www.ariljaa.mce.mn) платформын хэвийн үйл ажиллагааг хангаж, нэмэлт сайжруулалтыг талаар хөгжүүлэгч компанитай ярилцсан. Тус платформоор одоогийн байдлаар 239 зар нийтлэгдсэн бөгөөд долоо хоног бүр лхагва гарагт аймаг сумдын сошиал хаягууд дээр зарын мэдээллийг түгээж ажиллаж байна

5.4. Багцын гэрээний систем /www.bs.mce.mn/

“Санхүү мэдээллийн технологийн төв”-өөс И-баримт 3.0 системтэй тестийн орчинд ажиллах хөгжүүлэгч компаниас авдаг шалгалтад тус системийг хөгжүүлэгч компани болох “Майнд симбол” ХХК тэнцсэн. Одоогоор Санхүү мэдээллийн технологийн төв, Татварын ерөнхий газар, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК хамтарсан гурвалсан гэрээ гэрээ хийж аж ахуйн бирж нь мерчант бүртгэх оператор эрхээ авсан.

Багцийн гэрээний систем дээр “Цэц-Инвест” ХХК брокерийн компаний тосны ургамалын арилжаанд орсон 2 харилцагч дээр НӨАТ-ийн шивэлт, “Хаан тэлмэн” ХХК брокерийн арилжаанд орсон 10 харилцагч дээр НӨАТ шивэлтийг амжилттай илгээсэн.

Мөн дотоодын арилжааг дуудлага худалдааны системээр зохион байгуулж байгаатай холбогдуулан биелсэн хэлцлүүд дээр НӨАТ үүсгэх боломжтой болсон байна.

5.5. Агуулахын итгэмжлэлийн систем /www.itgemjlel.mce.mn/

Итгэмжлэлийн системийн ажиллах зарчим, бусад системүүдтэй холбогдох байдалд бизнес процессын шинэчлэлт хийж, бэлэн болсон системийг Үндэсний дата төв дээр зөөн байршуулсан. www.itgemjlel.mce.mn домейн хаяг байршуулан хэвийн найдвартай ажиллаж байна.

5.6. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /www.intranet.gov.mn/

Байгууллагын дотоод удирдлагын цогц систем болох “ABLE ERP” систем нь байгууллагын удирдлагын үйл ажиллагааг үр дүнтэй, хурдацтай явуулах, удирдах ажлыг хөнгөвчилсөн цахим систем бөгөөд байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, оффисын ажилд зайлшгүй шаардлагатай ажлуудыг цахим хэлбэрт шилжүүлсэн хэд хэдэн программуудаас бүрдсэн нэгдсэн систем юм.

Энэхүү системийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д нэвтрүүлж, систем дээр байгууллагын нийт албан хаагчдын ажлын байрыг үүсгэж, компанийн бүтцийг оруулж, ажилчдыг шинээр бүртгэн, компаний стратеги болон бизнес төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, албан бичгийн хөтлөлт, хэрэгжилт зэрэг албаны бүх модулыг ашиглан ажиллаж байна.

5.7. Компанийн веб хуудас /www.mce.mn/

Компанийн веб хуудас www.mce.mn домэйнээр ажиллаж, нэмэлт хөгжүүлэлт, шинэчлэлийг хийж ажиллав. Нийтийн ил тод мэдээллийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагатай мэдээллүүдийг цаг тухай бүрт шинэчилэн байршуулж байна. “Айтүүлс” ХК-тай уулзаж урсдаг үнийн мэдээлэл, арилжаа цэсний арилжааны index мэдээллийг гаргахаар ажиллаж байна.

5.8. Байгууллагын цахим шуудан үйлчилгээ

Байгууллагын цахим шуудангийн үйлчилгээний [@mce.mn/](mailto:@mce.mn) хэвийн үйл ажиллагааг ханган ажиллалаа. Одоогийн байдлаар 30 цахим шуудангийн хаягийг байгууллагын хэрэглээнд ашиглаж байна.

5.9. Байгууллагын гадаад, дотоод сүлжээ тоног төхөөрөмж

Компанийн дотоод, гадаад сүлжээний тоног төхөөрөмж, ажлын компьютер, дотуур холбоо бусад төхөөрөмжийн найдвартай аюулгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Байгууллагын 2025 худалдан авах төлөвлөгөөнд тусгасан ухаалаг дэлгэц, ухаалаг ТВ, байгууллагын ажилчдын ажлын компьютер, зөөврийн компьютерт хэрэглээний програм хангамж office 2019 Pro, Nod32 вирус хортой кодоос хамгаалах компьютерын хамгаалалтын лицензүүдийн худалдан авалт хийн нийт ажилчдын ажлын болон зөөврийн компьютер дээр суулгаж ажиллах хэвийн үйл ажиллагааг хангах боломжийг бүрдүүлсэн. Байгууллагын 2025 оны хэрэглээний програм, вирусны програмын албан ёсны лицензийг худалдан авч ажлын компьютерууд болон, зөөврийн компьютерууд дээр суулгаж хэвийн ажиллагаанд оруулсан.

ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА

Компанийн батлагдсан “Стратеги төлөвлөгөө 2022-2026”-нд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөр компанийн “Бизнес төлөвлөгөө 2025”-г батлуулан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэж байна.

6.1. Төрөөс хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилт:

Монгол Улсын Их Хурлаар баталсан тогтоолын хэрэгжилтийн талаар:

- Монгол Улсын Их Хурлын 2024 онд 63 дугаар тогтоолоор баталсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо” хөдөлгөөн болон хөдөө аж ахуйн салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхэд малын гаралтай түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, салбарын эдийн засгийг тогтвортой өсгөх, тэр дундаа арьс шир, ноос, ноосон бүтээгдэхүүн болон ноолуурын зах зээлийг тэлэх, экспортыг шинэ шатанд гаргахад хамтын ажиллагааны үр дүнтэй үйл ажиллагааг бүрдүүлж, холбогдох дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо” ТББ, “Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ болон “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-тай уулзалт хийж, “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан.
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасаны дагуу “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын хэсэг ажиллаж байна.
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд малын гаралтай түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгож, нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлж, гарал үүсэл, чанар нь баталгаажсан түүхий эдийг үндэсний үйлдвэрт нийлүүлэх, экспортлохыг дэмжих ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн биржийн системийг шинэчлэхээр тусгасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газар, Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, цаашид биржийн системд хийгдэх нэмэлт хөгжүүлэлтийн талаар санал солилцон шинэ системийн архитектур зураглал гаргаж санхүүжилтыг шийдвэрлэхээр тогтсон. Мөн Хөдөө аж ахуйн биржийн системийг шинэчлэх ажлын хүрээнд биржийн системийн хөгжүүлэгч “Ай түүлс” ХК, “Дижитал медик” ХХК, “Майнд симбол” ХХК, “Хөгжлийн шийдэл” ТББ – “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн дижитал хоршоог хөгжүүлэгч компани, “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХХК www.ubx.mn, Ард санхүүгийн нэгтгэл www.idax.mn зэрэг биржүүдийн гүйцэтгэх удирдлагуудтай уулзалт хийж, санал солилцсон.

➤ Монгол Улсын Их Хурлын 2024 онд 63 дугаар тогтоолоор баталсан “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Арьс ширэн түүхий эд бэлтэл-2025” төслийг ХХААХҮЯ-ны ХөҮБХЗГ, “Цагаан алт” ТББ, ЗБДС, Аймгуудын ХХААГ, “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо” ТББ-той хамтран хойд бүс, зүүн бүс, төвийн бүсэд танхимын хэлбэрээр, баруун бүс, говийн бүс, хангайн бүсэд цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, арьс шир бэлтгэл, хадгалалт, түүхий эдийн гэмтэл, анхан шатны тордолт, чанар хангах, биржийн арилжаанд оролцох талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг хийж, арьс ширний дуудлага худалдааг зохион байгуулсан.

➤ Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 9.5 дахь хэсэгт заасан Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-аас Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс 0.04 хувиар тогтоосон байдагыг “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн хугацаанд малын гаралтай түүхий эдийн арилжаанаас түр чөлөөлөх тухай санал бүхий Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан бичгийн төслийг боловсруулсан ба 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/3292 дугаар бүхий сайдын албан бичиг Санхүүгийн зохицуулах хороонд хүргэгдсэн. Тус албан бичгийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан мэдээлэл, тооцооллыг цаг тухай бүр хүргүүлж ажилласан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг бууруулж, түр чөлөөлөх тухай” 463 дугаар тогтоолоор 2024 оны 491 дүгээр тогтоолын хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл гэж өөрчилж, самнасан ноолуурын арилжааны хэлцлээс тооцох хувь хэмжээг 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл түр чөлөөлсөн.

➤ Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Их хурлын 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны 2025 оны “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоолын дагуу “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын 2025 оны А/08 дугаар тушаалаар батлуулан, мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооноос баталсан тогтоолын хэрэгжилтийн талаар:

➤ Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны “Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь мах, махан бүтээгдэхүүний экспортын худалдааг хөнгөвчлөх, экспортын гэрчилгээ олгох үйл явцыг хурдан шуурхай гүйцэтгэх зорилгоор “Экспортын нэг цонхны систем”-ийг хөгжүүлэн 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад нэвтрүүлсэн. Тус системд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Гаалийн ерөнхий газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори, Стандарт хэмжил зүйн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон төрийн бус

байгууллагууд холбогдсон ба экспортын гэрчилгээ авах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллага өмнө нь 13-15 өдөр зарцуулдаг байсаныг хөнгөвчилж 2 өдөрт багтаан шийдвэрлэдэг болсон. 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тус системээр “Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний импорт, экспорт, дамжин өнгөрөх мэдэгдэл”-ийн хүсэлтийг авч эхэлсэн ба энэ хугацаанд импортын мэдэгдлийг, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Мал, амьтны гаралтай түүхий эдийн үйлчилгээ”-г нэвтрүүлж, дамжин өнгөрөх мэдэгдэлийг тус тус олгож эхлээд байна. Энэхүү системээр ноос ноолуур, арьс шир, тосны ургамал зэрэг хөдөө аж ахуйн гаралтай 27 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтийг гүйцэтгэхээр систем хөгжүүлэлтийг хийж бэлэн болгосон.

➤ Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж, ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ноолуурын бэлтгэлийг хангуулах, үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр түүхий эд худалдан авалтын санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, түүнийг мөнгөжүүлэх, эргэн төлүүлэхтэй холбогдсон асуудлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанк, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ, Үндэсний үйлдвэр, Арилжааны банкууд хамтран ажиллаж байгаа бөгөөд бирж нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Арилжааны банк, Үндэсний үйлдвэр, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хамтарсан дөрвөлсөн гэрээний төслийг боловсруулж, талууд гэрээний зүйл заалтад санал өгч, эцэслэсэн. Мөн вексель бичигч үйлдвэрүүдэд векселийн үнэт цаас дээр бичилт хийх гарын авлагыг бэлтгэн гаргасан. “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь векселийн харилцаанд оролцохоор хүсэлт ирүүлсэн 17 аж ахуйн нэгжийн векселиэр худалдан авалт хийсэн ноолуурыг хадгалах түүхий эдийн агуулахын чанар, эрүүл ахуй, үйл ажиллагаа, камержуулалт, тоног төхөөрөмж зэрэгт шалгалт хийж, үйлдвэрийн дэргэдэх 2 агуулахыг биржийн “Итгэмжлэгдсэн агуулахад тавих шалгуур үзүүлэлт”-ийг хангуулан итгэмжлэл олгоод байна. 17 аж ахуйн нэгж нийт 158,1 сая төгрөгийн санхүүжилтийг векселиэр мөнгөжүүлэх хүсэлтийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д ирүүлсэнийг арилжааны банкуудад хүргүүлсэн.

Үүний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Ханбогд кашимер” ХХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-573/974 дугаартай 7 тэрбум төгрөгийн “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ”-г, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Говь” ХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-574 дугаартай 7 тэрбум төгрөгийн “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ” болон 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 250623/06-574-1 дугаартай боловсруулах үйлдвэрээс самнасан ноолуур худалдан авах тухай дөрвөлсөн гэрээнд оруулсан нэмэлт

өөрчлөлтийн төслийг боловсруулан эцэслэж, талууд гарын үсэг зурж баталгаажууллаа.

Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцож байгаа бөгөөд “Говь” ХК-ийн худалдан авсан ноолуурт хяналт тавьж, баталгаажуулалтыг гэрээний хавсралт маягтын дагуу гүйцэтгэн Голомт банк руу эх хувиар хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар векселиэр худалдан авсан ноолуурын эргэн төлөлт бүрэн хийгдэж, хэрэгжилт хангагдсан байна.

Монгол Улсын Засгийн Газраас баталсан тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийн талаар:

➤ “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зүйл заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршоонд суурилсан түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, боловсруулалт, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хоршоогоор дамжуулан хангуулах ажлын хүрээнд “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдийн үндэсний холбоо” ТББ, “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо” ТББ, “Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ болон “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-тай хамтран ажиллаж байна.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг мөрдөн ажиллахад хамтран ажиллах, /MNS ISO/IEC 17065:2013 стандарт баталгаажуулалтыг “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-аар хийлгэн баталгаажсан бараа, түүхий эдийг Хөдөө аж ахуйн биржээр арилжиж байна.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-ыг мөрдөх ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн мал, махыг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан эдийн засгийн эргэлтэнд оруулах, арилжааг зохион байгуулах талаар Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын удирдлагуудтай цахим уулзалт хийлээ. Уулзалтын үр дүнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монгол Улсад хэрэгжиж буй гадаадын төсөл хөтөлбөрийн төлөөлөл болон Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газар, Хөвсгөл аймгийн түүхий эдийн хоршоод, мах төхөөрөх болон боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөлүүдийг хамруулсан арга хэмжээг Хөвсгөл аймагт зохион байгуулахаар шийдвэрлэж бэлтгэл ажлыг ханган ажилласан боловч зарах болон авах талуудын мал, мах худалдаалах үнэ дээр тохиролцоонд хүрээгүй тул тус арга хэмжээ хойшилсон болно.

Компанийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ:

➤ “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь Дархан-Уул аймагт шилжин ирсэнтэй холбогдуулан “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ Дархан-Уул аймагт хүрэлцэн ирж биржийн үйл ажиллагаатай

танилцан цаашид хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

➤ Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан “Биржийн систем хөгжүүлэлтийн туршлага судлах, архитектур зураглал хийх, ижил төсөөтэй арилжааны системийн талаар судалгаа хийж, биржийн арилжааны системийн шинэчлэх хийх” ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хамрагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын хүрээнд Зөвлөх үйлчилгээ аван ажиллаж байгаа ба шаардлагатай мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна. “И-Гэрээ” ХХК-ийн зөвлөх Т.Гандуламтай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээ 2025 оны эцсээр дуусгавар болно.

➤ Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа болон Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүхтэй хоёр байгууллагын хамтын ажиллагаа болон Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний баталгаажуулалтын хэрэгжилтийн талаар уулзалт хийлээ. Тус уулзалтаар Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар харилцан санал солилцлоо. Хоёр байгууллагын хооронд экспортын үйл ажиллагаатай холбогдуулан харилцан мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна.

➤ “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Гүйцэтгэх захирал Б.Саруул, Худалдааны бодлогын газрын захирал Д.Адъяасүрэн нартай хоёр байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар экспортын баримт бичгийн бүрдүүлбэр, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Хөдөө аж ахуйн биржийн хууль эрхзүйн орчинг сайжруулж, бэхжүүлэх зэрэг асуудлуудаар хэлэлцэж, санал солилцсон ба “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь тус танхимын гишүүн боллоо.

➤ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн экспортын, гарал үүслийн, арилжааны мэдээний зөрүүг арилгах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгохтой холбоотой асуудлаар Гаалийн ерөнхий газартай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах тухай “Хамтын ажиллагааны гэрээ”-ний төслийг бэлтгэж, Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Энэхүү хамтын ажиллагааны асуудлаар Гаалийн ерөнхий газрын Хяналт бүрдүүлэлтийн газар, Статистик, дүн шинжилгээний хэлтэс, Хуулийн хэлтсийн дарга, ахлах байцаагч нартай албан уулзалт хийлээ. Уулзалтаар “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын хилээр гарч, орж буй хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд хяналт тавих арга хэмжээнд Гаалийн ерөнхий газартай гэрээ байгуулан хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж, санал солилцсон.

➤ 2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамал /рапс/-ын дотоодын болон импортын үрийг Хөдөө аж ахуйн биржийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлох арилжааг биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны зураглалын талаар экспортын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд танилцуулга мэдээллийг олгох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн

бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Салбарын хяналтын газар, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газар болон “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК хамтран зохион байгуулж, аж ахуйн нэгжүүдтэй харилцан санал солилцлоо. Хурлаар хэлэлцсэн асуудлыг оролцогчид 100 хувь дэмжиж, хурлын тэмдэглэлд гарын үсэг зуран баталгаажуулсан. Намрын ургац хураалтын урьдчилсан баланс гарсантай холбогдуулан дээрх экспортын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй дахин цахим уулзалт хийж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем болох www.plant.mofa.gov.mn системд тосны ургамал /рапс/-ын тариалалтын мэдээллийг заавал оруулсан байх шаардлагатай болохыг мэдэгдсэн.

➤ Биржийн “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”-ийн төлөвлөгөөний дагуу 2025 оны эрсдэлийн төлөвлөгөөг шинэчлэн гарган, боловсруулж, тус төлөвлөгөөний дагуу Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнээр дамжуулан үйл ажиллагааны чиглэл тус бүрээр хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн биржийн одоогийн бүтэц, зохион байгуулалт оновчтой эсэхийг тодорхойлж, гарч болох эрсдэл болон шаардлагатай орон тоог тодорхойлох ажлын хүрээнд биржийн нийт ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, одоогийн гүйцэтгэж буй ажил үүрэгт эрсдэл тодорхойлох маягтын дагуу эрсдэлийг бүртгэлжүүлж, ярилцлага, санал асуулга, шинжилгээгээр гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, цаашид шаардлагатай орон тоо, бүтцийг тооцоолон гаргасан. Мөн цаашид шаардлагатай байгаа бүтэц, орон тооны мэдээллээр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, танилцуулга мэдээллийг бэлтгэн боловсруулсан.

➤ “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүйд тооцох тухай” хуулийн төслийг Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдаас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж буйтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2024 онд 31 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд “Хөдөө аж ахуйн биржээр үрийн болон хүнсний улаанбуудайг арилжих талаар судалж, шийдвэрлэх”-ээр өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг гаргаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлээ. Мөн Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газар болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-тай хамтран Хөдөө аж ахуйн биржээр үрийн болон хүнсний улаанбуудайн арилжааг цаашид тогтмол зохион байгуулах, ургамлын гаралтай түүхий эдийн гарал үүсэл, мөшгих тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажиллах талаар уулзалт хийсэн. Уулзалтаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем болох www.plant.mofa.gov.mn системд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн захиалгын цэс нэмэлтээр үүсгэх талаар санал солилцсон. Системийн нэмэлт хөгжүүлэлтийн асуудалд төсөв хөрөнгө шаардлагатай тул эхний ээлжинд тус системд нэвтэрч мэдээлэл авах эрхийг Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас нээж өгсөн.

➤ Тосны ургамал /рапс/ тариалагч иргэн, аж ахуйн нэгж аливаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх боломжтой эсэх талаар мэдээлэл хүсэх тухай Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 261 дүгээр албан бичгийг Татварын ерөнхий газарт хүргүүлсэн ба Татварын ерөнхий газраас 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 05/3228 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн. Тус хариу албан бичигт тосны ургамал /рапс/ тариалагч иргэн, аж ахуйн нэгж аливаа татварын

хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамаарах хуулийн зохицуулалтгүй болох тухай дэлгэрэнгүй тайлбарыг ирүүлсэн байна. Үүнтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүсэлт тавьж “Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай” хуулийн 13 дугаар зүйлд заасан “үр тариа” нэр төрөлд хамаарах тосны ургамал ангилалд “рапс”-ыг оруулах боломжийг судлуулахаар тохиролцоод байна.

➤ Монголын байгалийн өв сангийн The Nature Conservancy олон улсын байгууллага буюу TNC байгаль хамгааллын байгууллагатай уулзалт хийлээ. Уулзалтаар тусгай хамгаалалттай бүсэд нутаглах малчдын мал болон малын гаралтай түүхий эдийг биржийн системээр дамжуулан эдийн засгийн эргэлтэнд оруулах, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллах талаар санал солилцож, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх эхлэлийг тавьлаа.

➤ Уур амьсгалын ногоон сан Green Climate Fund-ийн санхүүжилтээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон UNDP in Mongolia - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь - АДАПТ төсөл”-өөс зарласан баруун болон зүүн бүсийн “Мал, махны дуудлага худалдаа”-г зохион байгуулах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцож, шаардагдах бичиг баримтын бүрдэлийг ханган хүргүүлж шалгарсан. Малчдын бэлтгэсэн гарал үүсэл тодорхой, эрүүл ахуйн шаардлага хангасан, үйлдвэрийн чанарын шаардлагад нийцсэн мал, махыг зах зээлд борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилго бүхий баруун болон зүүн бүсийн “Мал, махны дуудлага худалдаа”-г Завхан аймгийн Улиастай суманд, Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд тус тус амжилттай зохион байгууллаа.

6.2. Судалгаа, мэдээлэл:

➤ Хөдөө аж ахуйн бирж үүсгэн байгуулагдахаас өмнө буюу 2003-2013 онд экспортолсон ноолуурын тоо хэмжээг Хөдөө аж ахуйн бирж байгуулагдсанаас хойш буюу 2013-2024 онд биржийн арилжаанд орсон ноолуурын тоо хэмжээний дүн болон үнийн мэдээллийг харьцуулан гаргаж нэгтгэн танилцуулсан.

➤ Хөдөө аж ахуйн биржээр арилжиж буй 8 бүлэг бараа, түүхий эдийн 2020-2024 оны экспортын мэдээлэлд боловсруулалт хийж, хамгийн өндөр үнийн дүнтэй экспорт хийж буй улс орныг бараа, түүхий эд тус бүрээр нь гаргаж танилцуулав. Мөн Гаалийн ерөнхий газрын экспортын мэдээлэл болон Хөдөө аж ахуйн биржийн арилжааны мэдээллийн тоо хэмжээний зөрүүг гаргав.

➤ Хөдөө аж ахуйн биржээр арилжаалж буй ноос, ноолуурын гарцыг жил, улирал, сараар тооцоолсон ба дотоодын үйлдвэрлэл болон экспортын хэмжээ, гадаад, дотоод зах зээлийн үнийн мэдээллийг 2023-2025 оны байдлаар гаргаж нэгтгэн танилцуулсан.

➤ Гүйцэтгэх захирлын 2025 оны А/22 дугаар тушаалаар “Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хэсэг”-ийг байгуулсан. Ажлын хэсэг компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн 4.5, 4.6 дахь хэсгийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан биржээр

арилжих барааны жагсаалтад буй бараа, түүхий эдийн зах зээлийн судалгааг хийж, тэдгээрийг биржээр дамжуулан арилжихад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгааг хийж танилцуулсан.

➤ Арилжааны танхимд салбарын дата анализын самбар бий болгох зорилгоор 5 хошуу малын тоо, мах, ноолуур, хонины болон тэмээний ноосны гарцыг 2030 он хүртэл 21 аймгийн хүрээнд боловсруулан гаргаж танилцуулсан.

➤ Ноолуурын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар НТВ мэдээллийн сувгийн бэлтгэсэн мэдээний хөтөлбөрт Хөдөө аж ахуйн биржээр арилжиж буй самнасан ноолуурын үнэ ханш, арилжааны мэдээ болон зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийн талаар ярилцлага мэдээлэл өгсөн.

➤ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтын арилжааг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК зохион байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын хэмжээн дэх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх махны худалдан авалтын тооцоолол, Дархан-Уул аймгийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх махны тооцоолол, хууль, эрх зүйн орчны судалгааг хийв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авалт хийх тендер шалгаруулалтад шалгарсан аж ахуй нэгж, иргэнийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх боломжийг эрэлхийлэн Дархан-Уул аймгийн Татварын газрын дарга Б.Жамсранжавтай уулзалт хийв. Уг уулзалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад оролцож байгаа аж ахуй нэгж иргэн нь “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13 дугаар зүйл. Албан татвараас чөлөөлөх тухай хэсгийн “13.1.29. Малчдын хоршоо, малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр” үндэслэн татвараас чөлөөлөгдөх эрх үүссэн байна.

➤ Caspy Commodity Exchange JSC Бүгд Найрамдах Казакстан Улсын таваарын биржийн танилцуулга, тус улсын хөрөнгийн биржийн хууль тогтоомж, Caspy Commodity Exchange JSC итгэмжлэл олгох журам зэрэг мэдээллийг бэлтгэв.

➤ 2026 онд Монгол Улсын хөгжилд биржийн гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх саналыг боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайд М.Бадамсүрэнд танилцуулсан.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

- Компанийн Дархан-Уул аймагт шилжин ирсэн хөдөлгөөнтэй холбогдуулан байгууллагын хаягийн өөрчлөлтийг хийлгэн Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга тэмдэгийг солив.
- Байгууллагын дотоод удирдлагын цогц систем болох “ABLE ERP” www.intranet.gov.mn/ системийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д нэвтрүүлж, Гүйцэтгэх захирлын А, Б тушаал, ирсэн албан бичиг болон мэргэжилтнүүдэд өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын төлөвлөлтийг тус системд бүртгэх, холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх зэрэг ажлуудыг тус тус гүйцэтгэж, системийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
- Биржийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, давхардлыг арилгах болон хэрэгжилт хангалтгүй зүйл, заалтыг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар нийт ажилтнуудын хурлаар хэлэлцэж, тодорхойлсноор хүчинтэй нийт 46 дүрэм, журам байгаагаас Гүйцэтгэх захирлын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/64 дугаар тушаалаар чиг үүргийн хувьд давхардсан, хэрэгжилт хангалтгүй байгааг хүчингүй болгож, одоогийн байдлаар нийт 23 дүрэм, журам мөрдөгдөж байна.
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасаны дагуу “Хөдөө аж ахуйн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлын хэсэг ажиллаж байна.
- “Хөдөө аж ахуйн бирж” ХХК нь 2025 онд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын гишүүнээр элслээ.
- Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/ болох “Хаан Тэлмэн” ХХК, “Ханбүргэд Хэнтий” ХХК, “Алтаншагай импекс” ХХК “Бадархундага Оргил” ХХК, “Роял кашимер” ХХК “Цэц-Инвест” ХХК-иуд биржийн арилжаанд оролцож байна. Тайлант хугацаанд 30 хоршоо биржтэй “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулан хамтран ажиллаж байна.
- Тайлант хугацаанд үйлдвэрийн дэргэдэх 20 агуулах, орон нутгийн 4 агуулах биржтэй “Агуулахын итгэмжлэлийн гэрээ” байгуулан хамтран ажиллаж байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг 2025 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоол гарсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолоор биржээр арилжсан самнасан ноолуурын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 0.62 хувь байхаар тогтоов.
- Монгол Улсын Их Хурлын 2024 онд 63 дугаар тогтоолоор баталсан “Цагаан алт” хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хоршоо” хөдөлгөөн болон хөдөө аж ахуйн салбарын урт, дунд хугацааны

хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэхэд малын гаралтай түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, салбарын эдийн засгийг тогтвортой өсгөх, тэр дундаа арьс шир, ноос, ноосон бүтээгдэхүүн болон ноолуурын зах зээлийг тэлэх, экспортыг шинэ шатанд гаргахад хамтын ажиллагааны үр дүнтэй үйл ажиллагааг бүрдүүлж, холбогдох дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо” ТББ, “Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ болон “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-тай уулзалт хийж, “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан.

➤ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор батлагдсан “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг мөрдөн ажиллах, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-тай байгуулсан санамж бичгийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд ноолуур, хонины ноос, завод ноосонд MNS ISO/IEC 17065:2013 стандартын дагуу баталгаажуулалтыг хийлгэж байна. 2025.06.17-12.31-ний өдрийн байдлаар 130 аж ахуйн нэгжийн 1933.5 тн хонины угаасан ноос, 1131.8 тн самнасан ноолуур, 130 тн завод ноосны баталгаажуулалт хийгдээд байна.

➤ Тайлант хугацаанд 164 удаагийн цахим арилжаа зохион байгуулж, 681 хэлцлээр 1,039.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 3,258 тонн самнасан ноолуур, 1,956 тонн ямааны завод ноос, 4,240 тонн хонины ноос, 1,007 тонн тэмээний ноос, 5,849 тонн тосны ургамал /рапс/-ын түүхий эдийн арилжаа зохион байгуулсан байна. Нийт 22.3 тэрбум төгрөгийн дэнчин, 121.6 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийн гүйлгээг программд шивж байршуулан арилжааны бэлтгэлийг ханган ажилласан ба клиринг, төлбөр тооцооны аливаа эрсдэл гараагүй, төлбөр тооцоо хугацаандаа хийгдсэн. Биржийн арилжаанд оролцсон 5 брокерын компанийн харилцагч 71 аж ахуйн нэгжид 839 ширхэг “Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт”-ыг олгосон байна.

➤ Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын 9.5 дахь хэсэгт заасан Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-аас Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс 0.04 хувиар тогтоосон байдагыг “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн хугацаанд малын гаралтай түүхий эдийн арилжаанаас түр чөлөөлөх тухай санал бүхий Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан бичгийн төслийг боловсруулсан ба 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/3292 дугаар бүхий сайдын албан бичиг Санхүүгийн зохицуулах хороонд хүргэгдсэн. Тус албан бичгийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан мэдээлэл, тооцооллыг цаг тухай бүр хүргүүлж ажилласан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг бууруулж, түр чөлөөлөх тухай” 463 дугаар тогтоолоор 2024 оны 491 дүгээр тогтоолын хугацааг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл гэж өөрчилж, самнасан ноолуурын арилжааны хэлцлээс тооцох хувь хэмжээг 2028 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл түр чөлөөлсөн.

- Тайлант хугацаанд “Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо” ТББ, Малын удмын сангийн үндэсний төв, “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа, Уур амьсгалын ногоон сан Green Climate Fund-ийн санхүүжилтээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон UNDP in Mongolia - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь - АДАПТ төсөл”-тэй хамтран 410.1 сая төгрөгийн 2,142 толгой амьд малын, 1.1 тэрбум төгрөгийн 96 тонн хэмжээ бүхий махны дуудлага худалдааг тус тус зохион байгууллаа.
- Гойд ашиг шимт малын “Шилмэл мал - 2025” үзэсгэлэн, дуудлага худалдаа 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Малын удмын сангийн үндэсний төв”-ийн байранд 36 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Тус дуудлага худалдаагаар Араб, Англи азаргийг 47 сая төгрөгөөр, “Герефорд” үүлдрийн 2 толгой бухан бярууг 18 сая төгрөгөөр тус тус арилжлаа.
- “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдсан “Арьс ширэн түүхий эд бэлтгэлийн хэлэлцүүлэг 2025” арга хэмжээний хүрээнд 204.8 сая төгрөгийн 6579 ширхэг арьс, ширний дуудлага худалдааг зохион байгууллаа.
- Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/164 дугаар тушаалын ажлын хэсэгт хамрагдаж, Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Баян булагтай сант” хоршоо, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын “Бумбат таван богд” хоршоодтой малын тэжээлийн туршилтын арилжааг зохион байгуулж, нийт 25.8 сая төгрөгийн 14 тонн хэмжээ бүхий “Малын тэжээлийн форвард” гэрээг байгуулав.
- Тайлант хугацаанд нийт 94.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2022, 2023, 2024, 2025 оны 1-4 дүгээр ангилалын 95,209.12 тонн хүнсний улаанбуудайг, 19.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 9 сортын 12,011.3 тонн үрийн улаанбуудайг, “Ачит агро” ХХК-ийн импортоор оруулж ирсэн 2025 оны хаврын тариалалтад шаардагдах нийт 3.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 190.1 тонн тосны ургамал /рапс/-ын үрийн дуудлага худалдааг тус тус дуудлага худалдааны www.cloud.mce.mn платформоор дамжуулан арилжсан.
- 2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамал /рапс/-ын дотоодын болон импортын үрийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлох арилжааг биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны зураглалын талаар экспортын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд танилцуулга мэдээллийг олгох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Салбарын хяналтын газар, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газар болон “Хөдөө аж ахуйн корпораци” ХХК хамтран зохион байгуулж, аж ахуйн нэгжүүдтэй харилцан санал солилцлоо. Хурлаар хэлэлцсэн асуудлыг оролцогчид 100 хувь дэмжиж, хурлын тэмдэглэлд гарын үсэг зуран баталгаажуулсан.

➤ Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн “Экспортын нэг цонхны систем” www.export.mofa.gov.mn/-ээр Мал эмнэлгийн ерөнхий газрын “Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ”-ний 5805 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс тус системээр ургамал, үр тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний импортын мэдэгдэл, дамжин өнгөрөх мэдэгдэлийн хүсэлтийг, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мал, амьтны гаралтай түүхий эд үйлчилгээний бусад төрлүүд нэвтэрч эхэлсэн. Тайлант хугацаанд импортын мэдэгдлийн гэрчилгээ 1953 ширхэг, дамжин өнгөрөх гэрчилгээ 1093 ширхэгийг шийдвэрлэгдсэн бөгөөд нийт 79 байгууллагад зөвлөгөө өгч, гадаад эзэнтэй 82 байгууллагын нэвтрэх эрх, компани төлөөлөх ажилтныг системд тохируулж өгсөн байна.

➤ Багцийн гэрээний систем www.bs.mce.mn/ дээр “Цэц-Инвест” ХХК брокерийн компаний тосны ургамалын арилжаанд орсон 2 харилцагч дээр НӨАТ-ийн шивэлт, “Хаан тэлмэн” ХХК брокерийн арилжаанд орсон 10 харилцагч дээр НӨАТ шивэлтийг тус тус амжилттай илгээсэн. Мөн дуудлага худалдааны хэлцэл дээр НӨАТ үүсгэдэг болсон.

➤ Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж, ахуйн байнгын хорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Ханбогд кашимер” ХХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-573/974 дугаартай 7 тэрбум төгрөгийн “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ”-г, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, “Голомт банк”, “Говь” ХК болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-574 дугаартай 7 тэрбум төгрөгийн “Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ” болон 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 250623/06-574-1 дугаартай боловсруулах үйлдвэрээс самнасан ноолуур худалдан авах тухай дөрвөлсөн гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан эцэслэж, талууд гарын үсэг зурж баталгаажууллаа.

Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцож байгаа бөгөөд “Говь” ХК-ийн худалдан авсан ноолуурт хяналт тавьж, баталгаажуулалтыг гэрээний хавсралт маягтын дагуу гүйцэтгэн Голомт банк руу эх хувиар хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар векселиэр худалдан авсан ноолуурын эргэн төлөлт бүрэн хийгдэж, хэрэгжилт хангагдсан байна.

➤ “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасаны дагуу “Хөдөө аж ахуйн биржийн системийн шинэчлэл хийх, системийн хөгжүүлэлтийн туршлага судлах, архитектур зураглал хийх, ижил төсөөтэй

арилжааны системийн талаар судалгаа хийх” чиг үүрэг бүхий ажлын хэсэгийг Гүйцэтгэх захирлын 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/07 тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын хүрээнд Зөвлөх үйлчилгээ аван ажиллаж байгаа ба шаардлагатай мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна. "И-Гэрээ" ХХК-ийн зөвлөх Т.Гандуламтай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээ 2025 оны эцсээр дуусгавар болно.

➤ Япон Улсын агуулахын барилгын үйл ажиллагаа эрхлэгч “Озава тент” ХХК-тай Монгол орны цаг уур, байгаль орчны нөхцөл, улирлын чанартай бэлтгэгдэж буй түүхий эдийн хадгалалтын горим, шаардлагад нийцэх зохицлыг тодорхойлох зорилгоор малын гаралтай бараа, түүхий эдийг хадгалах тентен хийц бүхий түүхий эдийн агуулахыг Монгол Улсад туршин, нэвтрүүлэх тухай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2024 онд байгуулсан. Биржийн “Ложистикийн төв”-ийн хашаанд барих туршилтын агуулахын барилгын ажлыг эхлүүлэх талаар хэлэлцэхээр тус компанийн төлөөлөгчид 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Дархан-Уул аймагт Гүйцэтгэх захиралтай уулзалт хийсэн ба барилгын ажлыг 2025 оны 8 дугаар сараас эхлүүлж, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өглөө. Тус тентэн агуулах нь мембран материалыг ашиглан агаарын давхарга үүсгэх технологид суурилсан өндөр чанарын агуулах бөгөөд -40 градуст тэсвэртэй, барихад хялбар гэдгээрээ онцлогтой юм.

➤ Гүйцэтгэх захирлын 2025 оны А/22 дугаар тушаалаар “Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хэсэг”-ийг байгуулсан. Ажлын хэсэг компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн 4.5, 4.6 дахь хэсгийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан биржээр арилжих барааны жагсаалтад буй бараа, түүхий эдийн зах зээлийн судалгааг гаргаж, тэдгээрийг биржээр дамжуулан арилжихад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгааг хийсэн.

➤ Компанийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, олон нийтэд түгээх зорилгын хүрээнд МҮОНРТ-тэй хамтран 2 удаагийн нэвтрүүлэг хийгдэж байгаагаас “Ухаалаг хөдөө аж ахуй” сэдэвт 29 минутын нэвтрүүлэг бэлтгэгдэж МҮОНРТ болон цахим хуудсаар олон нийтэд түгээн хүргэгдсэн байна.

➤ Тайлант хугацаанд компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 1,894,410 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 хувиар өссөн байна. Мөн цахим хуудасны зочилсон хэрэглэгчдийн тоо 32,822 байгаа нь мөн үетэй харьцуулбал 16.2 хувиар өссөн. Энэхүү үзүүлэлт нь цэвэр органик өсөлт бөгөөд нэмэлт төлбөртэй мэдээ байршуулалгүйгээр нэмж чадсан байна.

~o0o~